



# 2023 МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл

Улаанбаатар хот  
2024 он

# АГУУЛГА

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### НЭГ.ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### ХОЁР.ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ДҮН

- 2.1. Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаанд тавих
- 2.2. Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих
- 2.3. Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн маргаан хянан шийдвэрлэх
- 2.4. Төрийн зарим чиг үүргийг шүүхэд төлөөлөх үйл ажиллагаа

#### ГУРАВ. ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

- 3.1. Төрийн албаны ерөнхий шалгалт
- 3.2. Төрийн албаны тусгай шалгалт

#### ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ САХИУЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

#### ТАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА

- 5.1. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, урамшуулал
- 5.2. Чадахуйн зарчмын хэрэгжилтэд хийсэн хүний нөөцийн аудит
- 5.3. Сургалт, нөлөөллийн болон зөвлөн туслах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ
- 5.4. Судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэл
- 5.5. Төрийн албаны хүний нөөцийн их өгөгдөл
- 5.6. Төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлт
- 5.7. Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгох
- 5.8. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг чадавхжуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

#### ЗУРГАА. ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 6.1. Бүтэц, зохион байгуулалт бусад үйл ажиллагаа
- 6.2. Төрийн албаны Зөвлөлийн хуралдаан
- 6.3. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төсөл

#### ДОЛОО. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮГНЭЛТ

#### НАЙМ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ САНАЛ

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН 2023 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ

НЭГ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХӨДӨЛГӨӨН

ХОЁР. ТӨРИЙН НИЙТ АЛБАН ХААГЧИЙН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ

ГУРАВ. ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБАНЫ 2023 ОНЫ ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫН ДҮН МЭДЭЭ

ТАВ. ТЭТГЭВЭР ТОГТООЛГОСНЫ ДАРАА ТӨРИЙН АЛБАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТАЛААРХ ТООН МЭДЭЭ

ЗУРГАА. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТАЛААРХ ТООН МЭДЭЭ

ДОЛОО. ТӨРИЙН УЛС ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ

НАЙМ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ

ЕС. ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧИЙН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ

АРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛ

АРВАН НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН ТОО БҮРТГЭЛ /Байршлаар/

АРВАН ХОЁР. НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОГДОХ ЭРХ ХАСУУЛСАН ИРГЭДИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## НЭГ.ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн албаны тухай хуульд зааснаар Төрийн албаны төв байгууллага нь төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлж, улсын нэгдсэн санг бүрдүүлэх, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлж, мэдээллийг чанаржуулах зорилгоор төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийг “Иргэний бүртгэл”, “Боловсролын мэдээллийн сан”, “Хур”, “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”-тэй холбосон нь мэдээллийг боловсруулах, дамжуулах, солилцох, их өгөгдөл /data/-г ашиглах үйл ажиллагаанд үр нөлөө үзүүлж, бүртгэл мэдээллийн чанарт ахиц гарч байна.

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлд 2023 онд төрийн **4239** байгууллага, **226496** албан хаагч бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрийн албан хаагчийн тоо 1291 буюу 0.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд мэдээлэлд 2023 онд сургуулийн өмнөх боловсролын байгууллага 18, ерөнхий боловсролын сургууль 7, төв орон нутаг дахь захиргааны байгууллага 6, нийт 31 байгууллага шинээр бүртгэгдсэн байна.




Төрийн албан хаагчийн тоо нь Монгол Улсын нийт хүн амын 6.67 хувьтай тэнцэж, нийт ажиллах хүчний 18.2 хувийг эзэлж байна.

Тайлант онд төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөнд дараах өөрчлөлт, хөдөлгөөн орсон байна. Үүнд:

- Төрийн захиргааны албан тушаалд 5427, төрийн тусгай албан тушаалд 316, төрийн улс төрийн албан тушаалд 118, төрийн үйлчилгээний албан тушаалд 3036, нийт 8897 албан хаагч хууль, журмын дагуу томилогдсон;
- Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 31 байгууллага шинээр байгуулагдсантай холбоотой 1138 албан хаагч шинээр томилогдсон;
- Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, түүний харьяа 25 байгууллага татан буугдаж, албан хаагчид салбарын хяналтын чиг үүргийн байгууллагад шилжин томилогдсон;
- Албан тушаалын ангилал, зэрэглэлийн өөрчлөлтөөр Сайдын зөвлөх, бие төлөөлөгч, хэвлэлийн төлөөлөгчдийг төрийн улс төрийн албан тушаалд тооцсон;
- Хуульд заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдөн 613, чөлөөлөгдсөн 25203, нийт 25816 албан хаагч чөлөөлөгдсөн;
- Хуульд заасан үндэслэл, журмын дагуу төрийн байгууллага хооронд 862 албан хаагч шилжин, төрийн байгууллага, нэгж хооронд 421 албан хаагч сэлгэн ажилласан;
- Төрийн албанаас нийт 2001 албан хаагч халагдсан;
- Шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх хасах ялаар шийтгүүлсэн 217 иргэнийг төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд шинээр бүртгэж, 2020 оноос хойш өссөн дүнгээр 796 иргэн бүртгэгдсэн байна.

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний өөрчлөлтийг албан тушаалын ангилал тус бүрээр нь авч үзвэл:

- төрийн улс төрийн албан тушаалд 3898 албан хаагч бүртгэгдэж, нийт албан хаагчийн 1.72%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 139 албан хаагч буюу 3.6 хувиар;
- төрийн тусгай албан тушаалд 47657 албан хаагч бүртгэгдэж, нийт албан хаагчийн 21.04%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 499 албан хаагч буюу 1.0 хувиар;
- төрийн үйлчилгээний албан тушаалд 153302 албан хаагч бүртгэгдэж, нийт албан хаагчийн 67.68%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1037 албан хаагч буюу 0.7 хувиар тус тус өссөн.



Харин төрийн захиргааны албан тушаалд 21639 албан хаагч бүртгэгдэж, нийт албан хаагчийн 9.56% -ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 384 албан хаагч буюу 1.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

## Төрийн албан хаагчийн насны бүтэц

Насны бүтцийг авч үзвэл,

18-24 хүртэлх насны бүлэгт 18,224;

25-34 насны бүлэгт 70,290;


35-44 насны бүлэгт 69,740;

45-54 насны бүлэгт 51,727;

55-59 насны бүлэгт 12,425;


60-аас дээш насны 4,090 албан хаагч байна.

Төрийн албан хаагчийн насны дундаж 38.64 болж өмнөх оноос 1.51 жилээр буурч, төрийн албан хаагчийн дундаж наслалт залуужиж байгаа үзүүлэлттэй байна.



Төрийн албан хаагчийн 77.33 хувь нь бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.32 хувиар нэмэгдсэн байна. Төрийн албан хаагчийн боловсролын түвшин дээшилсэн.

## Төрийн албан хаагчийн боловсролын байдал



## Төрийн албан хаагчийн хүйсийн харьцаа, жендерийн үзүүлэлт

2023 оны тоо бүртгэлээр төрийн албан хаагчийн 67.7 хувь буюу **144183** нь эмэгтэй, 36.3 хувь буюу **82313** нь эрэгтэй байна. Нийт албан хаагчийн албан тушаалын ангиллаар авч үзвэл төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний албан хаагчийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр, төрийн улс төрийн болон төрийн тусгай албан хаагчийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь цөөн байна.



Төрийн албаны ангиллаар	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Эмэгтэй албан хаагчийн эзлэх хувь	Эрэгтэй албан хаагчийн эзлэх хувь
Төрийн захиргаа	14,323	7,316	21,639	66.20%	33.80%
Төрийн улс төр	901	2,997	3,898	23.10%	76.90%
Төрийн тусгай	13,049	34,608	47,657	27.4%	72.6%
Төрийн үйлчилгээ	115,910	37,392	153,302	75.60%	24.40%
<b>Нийт</b>	<b>144,183</b>	<b>82,313</b>	<b>226,496</b>	<b>63.70%</b>	<b>36.30%</b>

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгааны хэрэгжилтэд дүн шинжилгээ хийв. Үүнд:

- Төрийн улс төрийн албан тушаалтны сайд, дэд сайдын албан тушаалын хүйсийн харьцаа эмэгтэй 13.5 хувь, эрэгтэй 86.5 хувь;
- Аймаг, нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргын орлогч, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын албан тушаалын хүйсийн харьцаа эмэгтэй 10.5 хувь, эрэгтэй 89.5 хувь;
- Сумын Засаг дарга, сумын Засаг даргын орлогч, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын албан тушаалын хүйсийн харьцаа эмэгтэй 13.5 хувь, эрэгтэй 86.5 хувьтай дээрх хуульд заасан шаардлагыг хангаагүй байна.
- Дүүргийн Засаг дарга, дүүргийн Засаг даргын орлогч, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын албан тушаалын хүйсийн харьцаа эмэгтэй 27.3 хувь, эрэгтэй 72.7 хувь; баг, хорооны Засаг дарга нарын хүйсийн харьцаа эмэгтэй 23.7 хувь, эрэгтэй 76,3 хувьтай байна.<sup>1</sup>
- Төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудаас Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын албан тушаалын хүйсийн харьцаа эмэгтэй 11.4 хувь, эрэгтэй 88.6 хувь;
- Сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын хүйсийн харьцаа эмэгтэй 52.6, эрэгтэй 47.4 хувийг эзэлж, хуулийн хэрэгжилтийг хангаж байгаа боловч аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, ИТХ-ын


<sup>1</sup> Монгол Улсын хууль. Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль. 10.1.1. Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх

Нарийн бичгийн дарга нарын хүйсийн харьцаа 40 хувиас доошгүй байх хуулийн хэрэгжилт хангалтгүй байна<sup>2</sup>.




<sup>2</sup> Монгол Улсын хууль. Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль. 10.1.1. Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх





Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор хүйсийн харьцаа нь эмэгтэй 52.6 хувь, эрэгтэй 47.4 хувь байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангаж байна гэж дүгнэж болохоор байна.

Төрийн албан хаагчийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь сүүлийн 5 жилийн дунджаар 1.25 хувиар өссөн байх боловч 2023 онд 0.94 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Төрийн албан хаагчийн жендерийн харьцааг өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулахад төрийн улс төрийн албан тушаалд ажиллаж байгаа эмэгтэй албан хаагчийн тоо 1.0 хувиар өссөн, төрийн захиргааны болон төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 0.6-2.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн үйлчилгээний байгууллага түүний дотор сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, төрийн захиргааны болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах төрийн үйлчилгээний албан хаагчийн тоо 2038-аар буурсан нь нийт эмэгтэйчүүдийн тоо буурахад нөлөөлсөн байна. Харин төрийн захиргааны

эрэгтэй албан хаагч 299-өөр буурч, төрийн албаны бусад албан тушаалын ангилалд нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

*Төрийн албан хаагчийн жендерийн харьцаа /2022, 2023 онд эзлэх хувь, зөрүү/*

Төрийн албаны ангиллаар	Эмэгтэй				Эрэгтэй			
	2023 он	2022 он	Зөрүү/хувь		2023 он	2022 он	Зөрүү/хувь	
Төрийн захиргаа	14323	14408	(85)	-0.6%	7316	7615	(299)	-4.1%
Төрийн улс төр	901	892	9	1.0%	2997	2867	130	4.3%
Төрийн тусгай	13049	13318	(269)	-2.1%	34608	33840	768	2.2%
Төрийн үйлчилгээ	115910	116936	(1026)	-0.9%	37392	35329	2063	5.5%
Нийт	144183	145554	(1371)	-1.0%	82313	79651	2662	3.2%

*Төрийн үйлчилгээний байгууллага дахь жендерийн харьцаа /2022, 2023 онд эзлэх хувь, зөрүү/*

Д/д	Төрийн үйлчилгээний байгууллага	2023 он	2022 он	Зөрүү/хувь		2023 он	2022 он	Зөрүү/хувь	
		Эмэгтэй				Эрэгтэй			
1	Цэцэрлэг	27336	27119	217	0.8%	5334	5135	199	3.7%
2	Сургууль	43799	44667	-868	-2.0%	11877	12122	-245	-2.1%
3	Эрүүл мэндийн байгууллага	25354	24647	707	2.8%	6141	5488	653	10.6%
4	МСҮТ, ПК	2039	2203	-164	-8.0%	1164	1130	34	2.9%
5	Шинжлэх ухааны байгууллага	1146	1125	21	1.8%	992	907	85	8.6%
6	Соёл урлаг, спортын байгууллага	3990	3923	67	1.7%	2940	2773	167	5.7%
7	Төрийн захиргааны болон төрийн тусгай байгууллага	12246	13252	-1006	-8.2%	8944	7774	1170	13.1%
	Нийт	115,910	116,936	(1,026)	-0.9%	37,392	35,329	2,063	5.5%

### Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, төрөлд хамаарах тоон үзүүлэлт

#### Удирдах албан тушаалын үзүүлэлт:

Албан тушаалын төрлөөр нь ангилж үзвэл **16602** удирдах албан тушаалтан төрийн албанд ажиллаж байна. Үүнд:


- Төрийн захиргааны удирдах албан тушаалтан 2950 буюу 17.8%
- Төрийн тусгай удирдах албан тушаалтан 4624 буюу 27.8%
- Төрийн улс төрийн удирдах албан тушаалтан 3332 буюу 20.1%

- Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтан 5696 буюу 34.3%

Удирдах албан тушаалтны тоо өмнөх оны мөн үеэс 245 албан хаагчаар буурсан, хүйсийн харьцаа эмэгтэй 7045 буюу 42.4 хувь, эрэгтэй 9557 буюу 57.6 хувь байна.

#### Гүйцэтгэх албан тушаалын үзүүлэлт:

Албан тушаалын төрлөөр нь ангилж үзвэл **178880** гүйцэтгэх албан тушаалтан төрийн албанд ажиллаж байна. Үүнд:




2022 онд гүйцэтгэх албан тушаалтан 149450 байсан бөгөөд өмнөх оны үзүүлэлтээс 29430-аар өссөн байна.

Нийт гүйцэтгэх албан тушаалтны 119626 буюу 66.9 хувь нь эмэгтэй, 59254 буюу 33.1 хувь нь эрэгтэй албан тушаалтан байна.

#### Туслах албан тушаалын үзүүлэлт:

Албан тушаалын төрлөөр нь ангилж үзвэл **31014** туслах албан тушаалтан төрийн албанд ажиллаж байна. Үүнд:



Нийт туслах албан тушаалтны 17512 буюу 56.5 хувь нь эмэгтэй, 13502 буюу 43.5 хувь нь эрэгтэй албан хаагч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоол, түүний хавсралтаар батлагдсан **“Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-аар төрийн захиргааны албан тушаалын төрөлд туслах албан тушаал хасагдсан болно. Үүнтэй холбоотой өмнө нь туслах албан тушаалын ангилалд ажиллаж байсан албан хаагчид гүйцэтгэх албан тушаалд шилжсэн байна.**

### Төрийн албан хаагчийн ажилласан жилийн тоон үзүүлэлт

Төрд ажилласан жил	Төрийн захиргааны алба	Төрийн тусгай алба	Төрийн улс төрийн алба	Төрийн үйлчилгээний алба
0-5 жил	6379	47657	2222	62527
6-10 жил	4746		853	27856
11-15 жил	4100		374	21018
16-20 жил	2817		188	15534
21-25 жил	1674		134	10631
26-31 жил	1242		75	9271
32 жил түүнээс дээш	681		52	6465
<b>Нийт</b>	<b>21639</b>	<b>47657</b>	<b>3898</b>	<b>153302</b>

# ХОЁР.ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ДҮН

## 2.1. Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаанд тавих

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэх ажлыг эрчимжүүлэн ажиллалаа.

Төрийн албаны тухай хуульд Зөвлөл өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр хуульчилсны дагуу “Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020-2023 оны стратеги төлөвлөгөө”-нд туссан чадахуйн зарчимд нийцсэн мэргэшсэн албан хаагчдаар төрийн албыг бэхжүүлэх зорилтын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд бодитой, үр нөлөөтэй хяналт тавих, төрийн байгууллага, албан тушаалтанд арга зүйн зөвлөгөө өгөх, хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан мэдлэг боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлага бүхий албан хаагчийн эзлэх хувийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж тодорхой үр дүнд хүрэв.



Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг Улсын Их Хурал 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталж, энэ хууль 2 жил 8 сарын хугацаанд хэрэгжээд, үйлчлэх хугацаа нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

Хуулийн хэрэгжилтийг дуусгавар болсонтой холбогдуулан 2023 онд Төрийн албаны тухай хуулийн иргэнийг төрийн албанд томилохдоо чадахуйн зарчмыг баримталж төрийн албан тушаалын сул орон тоог нөхөх үндэслэл зөрчигдсөнөөр үүссэн томилгооны зөрчлийг хууль тогтоомжид нийцүүлэх шаардлага, хугацаатай үүрэг, даалгаврыг холбогдох төрийн байгууллага, салбар зөвлөлүүдэд өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.




### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана

### ТӨРИЙН АЛБАНЫ ЭРХЭМ ЗОРИЛГО

Төрийн албаны эрхэм зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.




2023 онд цар тахлын дараах төрийн албаны томилгоонд тавих хяналтыг эрчимжүүлсэн онцлог жил байсан бөгөөд цаашид төрийн албаны бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагааг

цахимжуулах зайлшгүй шаардлага гарч байна. Төрийн зарим давхардсан бүтцийг цэгцлэх, бүтээмж багатай, өрсөлдөх чадваргүй төрийн албан хаагчийг хөгжүүлэх, үйл ажиллагаанд менежмент, шинэлэг, шилдэг арга нэвтрүүлэх нь төрийн албаны шинэтгэлийн хамгийн чухал асуудал байгааг онцлон дүгнэж байна.



Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт "... төрийн албаны төв байгууллага өөрөө, эсхүл иргэний гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийнэ." гэж, 30.2 дахь хэсэгт "... хяналт, шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж сонгон шалгаруулалт явуулсан, төрийн албан хаагчийг томилсон нь тогтоогдсон бол зөрчлийг арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулна." гэж, 30.3 дахь хэсэгт "... үүрэг, даалгаврыг биелүүлээгүй бол төрийн албаны төв байгууллага хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгоно." гэж тус тус заасан.

Хуульд заасан дээрх чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг зөвлөн туслах, мэргэшил арга зүйгээр хангах, зөвлөмж, үүрэг даалгавар өгөх, сайн туршлагыг түгээх хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн.




Тайлант хугацаанд Зөвлөл өөрийн санаачилгаар болон иргэний гомдол, мэдээллийн дагуу 267 байгууллагын 4935 төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт зохион байгуулснаас 476 албан хаагчийг Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилсныг тогтоосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хяналт, шалгалтад хамрагдсан албан хаагчийн тоо 4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

***Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтад хамрагдсан байгууллага, албан хаагчийн тоо сүүлийн 5 жилээр:***



Төрийн албаны зөвлөлийн 12 удаагийн хуралдаанаар хяналт шалгалтын үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, 104 төрийн захиргааны байгууллагын 291 албан хаагчид холбогдох томилгооны зөрчил арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгч, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.



Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилогдсон 291 албан хаагчаас төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй 17, тусгай шалгалт өгөөгүй 192, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн тусгай шаардлага хангаагүй 11, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг зөрчсөн 10, “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ыг зөрчсөн 61 албан хаагч байна.

*Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн төрөл.*



**Төрийн албаны зөвлөлөөс төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт хяналт, шалгалтын талаар**

Төрийн албаны зөвлөл төлөвлөгөөт хяналт шалгалтаар нийт 17 удаагийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа зохион байгуулж, үүнд 257 байгууллагын 4734 албан хаагчийн сонгон шалгаруулалт, томилох үйл ажиллагааг хамруулсан. Хяналт шалгалтаар 451 төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албаны хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилсныг тогтоосон.

Зөрчилтэй томилгооны шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан хяналт шалгалтын явцад 172 албан хаагчид холбогдох зөрчлийг арилган, шийдвэрийг зөвлөлд ирүүлж хамтран ажилласан болно.

Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар 99 төрийн захиргааны байгууллагын зөрчил арилгаагүй 279 албан хаагчийн асуудлыг хэлэлцэн төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилсныг тогтоож, зөрчил арилгах хугацаатай үүрэг, даалгаврыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна.



Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилогдсон 279 албан хаагчаас төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй 17, тусгай шалгалт өгөөгүй 188, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн тусгай шаардлага хангаагүй 6, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг зөрчсөн 8, “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ыг зөрчсөн 60 албан хаагч байв.

*2023 оны Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын мэдээлэл*

№	Хяналт, шалгалтад хамрагдсан байгууллага	Хяналт, шалгалтад хамрагдсан албан хаагч	Зөрчилтэй томилгоотой албан хаагчийн тоо	Үүнээс				
				Зөрчлийг арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн	Зөрчлийг арилгасан	Түр түдгэлзсэн	Зөрчлийг арилгаагүй	Хугацаа болоогүй
<b>Нийт 257</b>		<b>4734</b>	<b>451</b>	<b>279</b>	<b>167</b>	<b>11</b>	<b>52</b>	<b>49</b>
<b>УИХ-аас удирдлага томилогддог 2 байгууллага</b>		<b>25</b>	<b>13</b>	<b>13</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>10</b>	<b>-</b>
1	Сонгуулийн ерөнхий хороо	15	3	3	3	-	-	-
2	Сонгуулийн ерөнхий	10	10	10	-	-	10	-



	хорооны дэргэдэх Мэдээлэл технологийн төв							
<b>4 дүүрэг /нийт 21 байгууллага/</b>		<b>626</b>	<b>111</b>	<b>71</b>	<b>20</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>49</b>
1	Чингэлтэй дүүрэг /нийт 5 байгууллага/	143	35	21	19	1	1	-
2	Сүхбаатар дүүрэг /нийт 5 байгууллага/	125	1	1	1	-	-	-
3	Хан-Уул дүүрэг /Нийт 6 байгууллага/	171	21	6	-	-	-	6
4	Баянзүрх дүүрэг /Нийт 5 байгууллага/	187	54	43	-	-	-	43
<b>11 аймаг /нийт 234 байгууллага/</b>		<b>4083</b>	<b>327</b>	<b>195</b>	<b>144</b>	<b>10</b>	<b>41</b>	<b>-</b>
1	Баян-Өлгий /нийт 24 байгууллага/	460	15	14	13	1	-	-
2	Баянхонгор /нийт 24 байгууллага/	495	59	43	30	2	11	-
3	Говьсүмбэр /нийт 26 байгууллага/	183	42	32	22	1	9	-
4	Дархан-Уул /нийт 18 байгууллага/	303	20	5	5	-	-	-
5	Дорноговь /нийт 25 байгууллага/	316	60	47	28	4	15	-
6	Орхон /нийт 17 байгууллага/	299	18	10	8	-	2	-
7	Өвөрхангай /нийт 22 байгууллага/	485	6	4	3	-	1	-
8	Сэлэнгэ /нийт 17 байгууллага/	325	43	6	4	1	1	-
9	Төв /нийт 20 байгууллага/	419	16	7	6	-	1	-
10	Ховд /нийт 21 байгууллага/	442	14	10	10	-	-	-
11	Хэнтий /нийт 20 байгууллага/	356	34	17	15	1	1	-

**Гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын талаар**

Иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн 10 байгууллагын 201 төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд нийт 10 удаагийн хяналт, шалгалт хийж 25 төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албаны хууль тогтоомж зөрчиж, төрийн жинхэнэ албан тушаалд томилсныг тогтоосон.

Зөрчилтэй томилгооны шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан хяналт шалгалтын явцад 13 албан хаагчид холбогдох зөрчлийг сайн дураар арилгаж, холбогдох шийдвэрийг зөвлөлд ирүүлсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хяналт, шалгалтын ажлын хэсгийн тайланг хэлэлцэж, 5 төрийн захиргааны байгууллагын 12 албан хаагч Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилсныг тогтоож, зөрчил арилгах хугацаатай үүрэг, даалгаврыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлээ.

*Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын мэдээлэл*

№	Хяналт, шалгалтад хамрагдсан байгууллага	Хяналт, шалгалтад хамрагдсан хаагчийн тоо	Зөрчилтэй томилгоотой албан хаагчийн тоо	Үүнээс			
				Зөрчлийг арилгах хугацаатай, үүрэг даалгавар өгсөн	Зөрчлийг арилгасан	Зөрчлийг арилгаагүй	Хугацаа болоогүй
<b>Нийт 10</b>		<b>201</b>	<b>25</b>	<b>12</b>	<b>10</b>	<b>2</b>	<b>-</b>
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	70	16	4	2	2	-
2	Зам, тээврийн хөгжлийн яам	120	6	5	5	-	-
3	Эдийн засаг хөгжлийн яам	1	1	1	1	-	-
4	Архивын ерөнхий газар	1	1	1	1	-	-
5	Налайх дүүрэг /1 байгууллага/	1	-	-	-	-	-
6	Архангай /2 байгууллага/	2	1	1	1	-	-
7	Булган /1 байгууллага/	4	-	-	-	-	-
8	Дорнод /1 байгууллага/	1	-	-	-	-	-
9	Өмнөговь /1 байгууллага/	1	-	-	-	-	-

Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилогдсон 12 албан хаагчаас төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй 4, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн тусгай шаардлага хангаагүй 5, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг зөрчсөн 2, “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ыг зөрчсөн 1 албан хаагч байв.

*Төлөвлөгөөт бус хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг агуулгаар авч үзвэл*



### **Төрийн албаны зөвлөлийн “Зөрчил арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгөх тухай” тогтоолын хэрэгжилтийн талаар**


Тайлант онд Монгол Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог 2 байгууллага, 3 яам, 1 агентлаг, мөн 15 аймаг, нийслэлийн 5 дүүрэгт хамаарах нийт 267 төрийн байгууллагын 4935 төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд нийт 27 удаагийн хяналт, шалгалтыг зохион байгуулав. Үүнээс 476 төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албаны хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилсныг тогтоосон.

Төрийн албаны зөвлөлийн 12 удаагийн хуралдаанаар хяналт, шалгалтын 27 ажлын хэсгийн тайланг хэлэлцэж, 104 төрийн захиргааны байгууллагын 291 албан хаагчийг Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилсныг тогтоож, зөрчил арилгах хугацаатай үүрэг, даалгаврыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр хууль тогтоомж зөрчиж томилогдсон 291 албан хаагчид зөрчил арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгснөөс 177 албан хаагчид холбогдох 25 тогтоол биелэгдсэн. Төрийн байгууллагын 54 албан хаагчид холбогдох 14 тогтоолыг биелүүлсэн эсэх талаарх баримт, тайлбарыг эрх бүхий албан тушаалтан тогтоосон хугацаанд ирүүлээгүй, 49 албан хаагчид холбогдох 2 тогтоолыг хэрэгжүүлэх тогтоосон хугацаа болоогүй байна.


Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөөтэй болон шүүхэд хандсан 11 албан хаагчид хамаарах зөрчил арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг Зөвлөлөөс түр түдгэлзүүлээд байна.

*Төрийн албаны зөвлөлийн 2023 оны "Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг өгөх тухай" тогтоолын биелэлт*



Төрийн албаны зөвлөлийн "Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг өгөх тухай" тогтоолыг хэрэгжүүлээгүй 54 томилгооны зөрчлийн шийдвэрийн тухайд авч үзвэл, Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын удирдлагын 10, яамны Төрийн нарийн бичгийн даргын 2, агентлагийн даргын 1, аймаг, дүүргийн Засаг даргын 2, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 5, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын даргын 34 шийдвэр байна.

*Төрийн албаны зөвлөлийн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг, даалгаврыг биелүүлээгүй төрийн байгууллагын тоон мэдээлэл*



## 2.2. Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан “төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоо бүрдэж, ёс зүйтэй төрийн алба төлөвшинө” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай, Прокурорын тухай, Төрийн аудитын тухай, Төсвийн тухай хууль тогтоомжийн хүрээнд эрх бүхий этгээд хяналт тавин ажиллаж байна.

Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал нь төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорын тухай ойлголт бөгөөд Төрийн албаны зөвлөл хууль тогтоомжид заасны дагуу зөвхөн иргэн, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсантай холбоотой асуудлаар төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.


Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж, 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж тус тус заасан.

Төрийн албаны зөвлөл хуульд заасан чиг үүргийн хүрээнд 2023 онд нийт 201 шүүхийн шийдвэрийн талаарх бүртгэл хөтөлж, нэр бүхий 135 иргэн, албан тушаалтанд холбогдох 1,817,123,820 (*нэг тэрбум найман зуун арван долоон сая нэг зуун хорин гурван мянга найман зуун хорь*) төгрөгийн үнийн дүн бүхий төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлсэн. Үүнээс 10 албан тушаалтан 103,692,484 (*нэг зуун гурван сая зургаан зуун ерэн хоёр мянга дөрвөн зуун наян дөрөв*) төгрөгийг төрд нөхөн төлсөн.


Мэдээллийн дагуу төрийг хохиролгүй болгох арга хэмжээ аваагүй 124 албан тушаалтанд холбогдох 1,764.718.231 (*нэг тэрбум долоон зуун жаран дөрвөн сая долоон зуун арван найман мянга хоёр зуун гучин нэг*) төгрөгийн үнийн дүн бүхий төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр төрийн төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргаснаас, шүүх 451,767,264 (*дөрвөн зуун тавин нэгэн сая долоон зуун жаран долоон мянга хоёр зуун жаран дөрөв*) төгрөгийн үнийн дүн бүхий 45 нэхэмжлэлийг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаас гаргуулахаар шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэрийн дагуу тайлант онд төрийн санд 2023 онд 253,679,038 (*хоёр зуун тавин гурван сая зургаан зуун далан есөн мянга гучин найм*) төгрөг төвлөрүүлж, 35 иргэн, албан тушаалтанд холбогдох 350,035,599 (*гурван зуун тавин сая гучин таван мянга таван зуун ерэн ес*) төгрөгийг албадан гаргуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандсан болно.

Тайлбар: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлагад тусгагдсан үнийн дүн хасагдах, зарим нотлох баримтад үндэслэн нэхэмжлэлийн үнийн дүн нэмэгдэх зэргээс хамаарч тайланд тусгагдсан тоон мэдээлэл зөрүүтэй харагдана.

Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд гаргасан нэхэмжлэл, хохирлын хэмжээ



Төрд учруулсан хохирлын нөхөн төлөлт



### 2.3. Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсэн маргаан хянан шийдвэрлэх


Төрийн албаны зөвлөлд төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх, ашиг сонирхол зөрчигдсэн тухай 479 гомдол ирүүлснээс 46 гомдолд маргаан үүсгэн хянан шийдвэрлэсэн.

Маргаан үүсгэж, хянан шалгасан гомдлын эзлэх хувийг өмнөх онуудтай харьцуулахад 2021 оноос 49 хувиар, 2022 оноос 27 хувиар тус тус буурч, Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт жил бүр сайжирч, үр нөлөө үзүүлж байна.

Энэ нь Төрийн албаны зөвлөлөөс хяналт шалгалтын цар хүрээг нэмэгдүүлж зөрчлийг таслан зогсоох чиглэлээр тогтмол арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж, шийдвэрийн

хэрэгжилтэд хяналт тавьж, төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зэрэг арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсний үр дүн гарч байна.

2019-2023 онд үүсгэсэн маргаан болон маргаан шийдвэрлэлтийн тоон үзүүлэлт



Эрх бүхий албан тушаалтан, төрийн албан хаагчийн хооронд үүссэн маргаан бүхий захиргааны 46 актыг агуулгаар нь авч үзвэл, 52.2% буюу 24 шийдвэр нь сахилгын шийтгэл ногдуулсан, 19.6% буюу 9 шийдвэр нь албан тушаалаас нь түр чөлөөлсөн, чөлөөлсөн, 10.8% буюу 5 шийдвэр нь төрийн албанаас халсан, 8.7% буюу 4 шийдвэр нь төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаал бууруулсан, 6.5% буюу 3 шийдвэр нь албан тушаалд сонгон шалгаруулж томилохтой холбоотой, 2.2% буюу 1 шийдвэр нь албан хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой асуудлаар гаргасан байна.

Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргаан агуулгаар



Маргаан бүхий захиргааны 46 актыг гаргасан албан тушаалтнаар ангилж үзвэл, 26.1% буюу 12 шийдвэрийг улс төрийн албан тушаалтан, 65.2% буюу 30 шийдвэрийг төрийн захиргааны албан тушаалтан, 8.7% буюу 4 шийдвэрийг төрийн тусгай албан тушаалтан гаргажээ.

Харин 16 гомдлын тухайд маргаан үүсгэн хянан шалгах явцад зөрчил арилсан, шүүхэд хандсан, тухайн албан тушаалд гомдол гаргагч хууль бусаар томилогдсон нь тогтоогдсон, гомдлоосоо татгалзсан, харьяаллын бус маргаан болохыг тогтоосон зэрэг үндэслэл тогтоогдсон тул холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гомдолд гаргагчид зохих хариуг өгсөн.

Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар маргаан хянан шалгах комиссын 30 дүгнэлтийг хэлэлцэж 60% буюу 18 шийдвэрийг Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчсөнийг тогтоон хүчингүй болгож, 40% буюу 12 шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэд тооцон хэвээр үлдээн шийдвэрлэсэн.

Хүчингүй болгосон шийдвэрийн жагсаалт

№	Маргаан үүсгэсэн тушаалын огноо, дугаар	Маргаан үүсгэсэн хуулийн үндэслэл	Гомдол, маргааны агуулга	Маргаан хянан шийдвэрлэсэн Зөвлөлийн тогтоол	Шийдвэрлэсэн байдал
1	2023.01.26 №16	ТАТХ-ын 48 дугаар зүйл, /Сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой/	Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Б/53 дугаар тушаалыг эс зөвшөөрч	2023.02.15 №48	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
2	2023.01.26 №17	ТАТХ-ын 48 дугаар зүйл, /Сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой/	Засгийн газрын агентлагийн даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Б/193, мөн өдрийн "Б/195 дугаар тушаалыг тус тус эс зөвшөөрч	2023.03.14 №76	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
3	2023.01.20 №12	ТАТХ-ын 47 дугаар зүйл, /албан тушаалаас халсантай холбоотой/	Сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Б/39 дүгээр захирамжийг эс зөвшөөрч	2023.03.14 №78	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
4	2023.03.10 №43	ТАТХ-ын 48 дугаар зүйл, /Сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой/	Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/58 дугаар захирамжийг эс зөвшөөрч	2023.03.28 №93	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
5	2023.03.10 №42	ТАТХ-ын 48 дугаар зүйл, /Сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой/	Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын даргын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Б/18 дугаар тушаалыг эс зөвшөөрч	2023.04.25 №147	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
6	2023.04.17 №58	ТАТХ-ын 45 дугаар зүйл, /Албан тушаал бууруулсантай холбоотой/	Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Б/15 дугаар захирамжийг эс зөвшөөрч	2023.05.30 №194	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
7	2023.06.02 №83	ТАТХ-ын 45 дугаар зүйл, /Албан тушаал бууруулсантай холбоотой/	Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын 2023 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн Б/10 дугаар тушаалыг эс зөвшөөрч	2023.06.07 №210	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
8	2023.06.28 №112	ТАТХ-ын 48 дугаар зүйл, /Сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой/	Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын даргын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 66 дугаар тушаалыг эс зөвшөөрч	2023.08.30 №369	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
9	2023.08.23 №132	ТАТХ-ын 66 дугаар зүйл, /сонгон шалгаруулалттай холбоотой/	Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлөөс 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан ... албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг хүчингүй болгуулах	2023.09.06 №378	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
10	2023.07.17 №118	ТАТХ-ын 48 дугаар зүйл, /Сахилгын шийтгэл	Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн Б/102 дугаар тушаалыг эс зөвшөөрч	2023.09.06 №377	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.



		ногдуулахтай холбоотой/			
11	2023.06.28 №109	ТАТХ-ын 45 дугаар зүйл, /Албан тушаал бууруулсантай холбоотой/	Сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/30 дугаар захирамжийг эс зөвшөөрч	2023.10.06 №420	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
12	2023.09.11 №142	ТАТХ-ын 66 дугаар зүйл, /сонгон шалгаруулалттай холбоотой/	Дүүргийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч, Засаг даргын орлогчийн 2023 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн Б/210 дугаар тушаалыг эс зөвшөөрч	2023.10.12 №425	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
13	2023.11.28 №200	ТАТХ-ын 45 дугаар зүйл, /Албан тушаал бууруулсантай холбоотой/	Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн Б/282 дугаар тушаалыг эс зөвшөөрч	2023.12.05 №525	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
14	2023.11.08 №184	ТАТХ-ын 46 дугаар зүйл, /Түр чөлөөлсөн, чөлөөлсөнтэй холбоотой/	Сайдын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Б31 дүгээр тушаалыг эс зөвшөөрч	2023.12.05 №524	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
15	2023.11.17 №193	ТАТХ-ын 46 дугаар зүйл, /Түр чөлөөлсөн, чөлөөлсөнтэй холбоотой/	Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Б/154 дүгээр тушаалыг эс зөвшөөрч	2023.12.20 №574	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
16	2023.12.05 №209	ТАТХ-ын 46 дугаар зүйл, /Түр чөлөөлсөн, чөлөөлсөнтэй холбоотой/	Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн даргын 2023 оны 11 сарын 01-ний өдрийн Б/153 дугаар тушаалыг эс зөвшөөрч	2023.12.20 №575	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
17	2023.11.30 №202	ТАТХ-ын 46 дугаар зүйл, /Түр чөлөөлсөн, чөлөөлсөнтэй холбоотой/	Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн Б/114 дүгээр тушаалыг эс зөвшөөрч	2024.02.07 №27	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.
18	2023.12.20 №220	ТАТХ-ын 46 дугаар зүйл, /Түр чөлөөлсөн, чөлөөлсөнтэй холбоотой/	Сумын Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Б/32 дугаар захирамжийг эс зөвшөөрч	2024.01.31 №21	Маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэв.


Төрийн албаны зөвлөл хууль бус болохыг тогтоож хүчингүй болгосон шийдвэрийн 11 буюу 61.1 хувийг төрийн захиргааны албан тушаалтан, 7 буюу 38.9 хувийг төрийн улс төрийн албан тушаалтан гаргасан байна.

Дээрх шийдвэрийг агуулгаар нь ангилбал:

- 33.3% буюу 6 шийдвэр нь сахилгын шийтгэл ногдуулсан;
- 27.8% буюу 5 шийдвэр нь албан тушаалаас нь түр чөлөөлсөн, чөлөөлсөн;
- 22.2% буюу 4 шийдвэр нь төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаал бууруулсан;
- 11.1% буюу 2 шийдвэр нь албан тушаалд сонгон шалгаруулж томилохтой холбоотой;
- 5.6% буюу 1 шийдвэр нь төрийн албанаас халсан.

### Хүчингүй болгосон шийдвэрийг агуулгаар

■ Сахилгын шийтгэл ■ Чөлөөлсөн ■ Буруулсан ■ Сонгон шалгаруулах ■ Халсан



Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар төрийн албан хаагч болон уг албанд нэр дэвшигчийн хооронд үүссэн төрийн албаны хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэж, хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгосон нийт 18 тогтоолын 10 буюу 55.6 хувийг холбогдох эрх бүхий албан тушаалтан биелүүлсэн, 4 буюу 22.2 хувийг эс зөвшөөрч шүүхэд хандсан, 3 буюу 16.7 хувийг эрх бүхий албан тушаалтан биелүүлээгүй, 1 буюу 5.5 хувийг хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна.

#### Хэрэгжилт хангаагдаагүй болон шүүхэд хандсан шийдвэрийн жагсаалт

№	Маргаан үүсгэсэн тушаалын огноо, дугаар	Маргаан үүсгэсэн хуулийн үндэслэл	Гомдол, маргааны агуулга	Маргаан хянан шийдвэрлэсэн Зөвлөлийн тогтоол	Тайлбар
1	2023.01.20 №12	ТАТХ-ын 47 дугаар зүйл, /албан тушаалаас халсантай холбоотой/	Сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Б/39 дүгээр захирамжийг эс зөвшөөрч	2023.03.14 №78	Зөвлөлийн шийдвэрийг биелүүлж, хариу ирүүлээгүй.
2	2023.03.10 №43	ТАТХ-ын 48 дугаар зүйл, /Сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой/	Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/58 дугаар захирамжийг эс зөвшөөрч	2023.03.28 №93	Зөвлөлийн шийдвэрийг биелүүлж, хариу ирүүлээгүй.
3	2023.04.17 №58	ТАТХ-ын 45 дугаар зүйл, /Албан тушаал бууруулсантай холбоотой/	Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Б/15 дугаар захирамжийг эс зөвшөөрч	2023.05.30 №194	Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд хандсан.
4	2023.06.28 №112	ТАТХ-ын 48 дугаар зүйл, /Сахилгын шийтгэл ногдуулахтай холбоотой/	Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын даргын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 66 дугаар тушаалыг эс зөвшөөрч	2023.08.30 №369	Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд хандсан.
5	2023.11.28 №200	ТАТХ-ын 45 дугаар зүйл, /Албан тушаал бууруулсантай холбоотой/	Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн Б/282 дугаар тушаалыг эс зөвшөөрч	2023.12.05 №525	Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд хандсан.

6	2023.11.08 №184	ТАТХ-ын 46 дугаар зүйл, /Түр чөлөөлсөн, чөлөөлсөнтэй холбоотой/	Сайдын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Б31 дүгээр тушаалыг эс зөвшөөрч	2023.12.05 №524	Зөвлөлийн шийдвэрийг биелүүлж, хариу ирүүлээгүй.
7	2023.11.30 №202	ТАТХ-ын 46 дугаар зүйл, /Түр чөлөөлсөн, чөлөөлсөнтэй холбоотой/	Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн Б/114 дүгээр тушаалыг эс зөвшөөрч	2024.02.07 №27	Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд хандсан.

## 2.4. Төрийн зарим чиг үүргийг шүүхэд төлөөлөх үйл ажиллагаа

Төрийн албаны зөвлөл нь төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар Төрийн албаны тухай хуульд заасан зарим чиг үүргийг хэрэгжүүлэн, шүүхэд төлөөлөн оролцож, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу төрд учруулсан гэм хорын хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэгчээр, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн иргэн, албан хаагчийн гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож ажилладаг.

Төрийн албаны тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд иргэний 43 хэрэгт нэхэмжлэгчээр, захиргааны 21 хэрэгт хариуцагчаар, эрүүгийн 1 хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тус тус оролцсон байна.

Эрүү, иргэн, захиргааны нийт 65 хэрэгт шүүхэд төлөөлөл хэрэгжүүлэхдээ давхардсан тоогоор анхан шатны шүүх хуралдаанд 170, давж заалдах шатны шүүх хуралдаанд 26, хяналтын шатны шүүх хуралдаанд 3 удаа оролцсон байна.

Шүүх хуралдаанд оролцсон байдал



Төрийн албаны зөвлөлийн даргын шийдвэрээр шүүхэд төлөөлж буй хэргийн тоо



Төрд учруулсан гэм хорын хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх чиг үүргийн хүрээнд Төрийн албаны тухай хууль /2002 он/-ийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын үйлчлэлд хамаарах Төрийн албаны зөвлөлийн нэхэмжлэлтэй төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага бүхий, хүчингүй болсон хуулийн заалтыг буцаан хэрэглэж, иргэн, албан хаагчийн эрх зүйн байдлыг дордуулсан гэх маргаантай иргэний хэргийг Улсын дээд шүүхээр эцэслэн шийдвэрлүүлж, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, буруутай албан тушаалтанд эдийн засгийн хариуцлага тооцсон жишиг шүүхийн шийдвэр гарсан.

Түүнчлэн төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой захиргааны хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг эс зөвшөөрч, захиргааны шийдвэр гаргадаг төрийн байгууллага, албан тушаалтан шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхгүй талаар захиргааны хэргийн шат шатны шүүхийн жишиг шийдвэрүүд гарч, хууль хэрэглээний шинэ практик тогтоосон нь Зөвлөлийн шийдвэрийг холбогдох этгээд заавал биелүүлдэг байх зарчим хэрэгжих нөхцөл бүрдэж, Зөвлөлийн шийдвэрийн хүчин чадал, ач холбогдол нэмэгдсэн.

Тайлант хугацаанд төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэсэн Зөвлөлийн 3 тогтоолыг зарим төрийн байгууллага, албан тушаалтан эс зөвшөөрч, шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд эцэслэн шийдвэрлэгдээгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байна.

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд төрийн зарим чиг үүргийг шүүхэд төлөөлсөн байдлын өсөлт, бууралтыг сүүлийн 5 жилээр хүснэгт болон графикаар авч үзвэл:

Шүүхэд төлөөлж буй хэргийн тоо

№	Он	Иргэний хэрэг /нэхэмжлэгч/	Захиргааны хэрэг /хариуцагч/	Эрүүгийн хэрэг /Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч/
1	2019	2	5	0
2	2020	3	14	0
3	2021	6	17	0
4	2022	11	24	0
5	2023	43	21	1
<b>Нийт</b>		<b>65</b>	<b>81</b>	<b>1</b>

Шүүх хуралдааны тоо

№	Он	Анхан шатны шүүх	Давж заалдах шатны шүүх	Дээд шүүх
1	2019	2	5	5
2	2020	3	14	10
3	2021	6	17	20
4	2022	140	41	1
5	2023	321	103	39
<b>Нийт</b>		<b>472</b>	<b>180</b>	<b>75</b>

Төрийн албаны зөвлөл төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах, хугацаатай үүрэг даалгавар хүргүүлж, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох чиг үүргийг хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрч байна.

Салбарын хүний нөөцийн урт хугацааны бодлогогүй, төрийн жинхэнэ албан тушаалд тавих тусгай шаардлагыг хууль тогтоомжид өөрчлөлт оруулан, тодорхой үндэслэлгүйгээр бууруулах, төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллагад бүтцийн өөрчлөлтийг удаа дараа зохион байгуулах, салбарын хэмжээнд тогтворгүй байдлыг үүсгэх, орон тоог үндэслэл судалгаагүйгээр нэмэгдүүлэх, төрийн албан дахь цалингийн нэгдсэн бодлого алдагдаж адил ангилал, зэрэглэлд цалин хөлс харилцан адилгүй болсон, хууль зөрчиж сонгон шалгаруулалтгүйгээр томилогдсон албан хаагчдыг төрийн албаны түшмэлийн зохих ангиллын албан тушаалд ажилласан хугацаанд тооцох зэргээс шалтгаалан төрийн алба хаах адил тэгш боломж алдагдах, хууль тогтоомжийг зөрчих зөрчил тасрахгүй байсаар байна.

Эрх бүхий албан тушаалтны зүгээс төрийн албаны хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилох тохиолдолд буурч, үр дүнд хүрч байгаа нь Төрийн албаны зөвлөлөөс өнгөрсөн хугацаанд эрчимтэй зохион байгуулсан хяналт шалгалтын үйл ажиллагаа болон хууль зөрчсөнөөр төрд учруулсан хохирлыг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх ажлыг эрчимжүүлсэнтэй холбоотой гэж үзэж байна.

## ГУРАВ. ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-д заасан төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж төрийн албаны ерөнхий шалгалтыг улиралд нэгээс доошгүй удаа төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй иргэд болон төрийн улс төр, үйлчилгээний албан хаагчаас, тусгай шалгалтыг төрийн захиргааны албан тушаалын ангилал хооронд шилжих тохиолдолд, төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог өрсөлдөөний үндсэн дээр нөхөх шинэ зохицуулалтууд тусгагдсан.

Төрийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, төрийн бүтээмжийн сэргэлтийг дэмжих, төрийн албаны шалгалтыг төрийн байгууллагын бодит эрэлт хэрэгцээнд тулгуурлан хүндрэл чирэгдэлгүй, шуурхай, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулж, сонгон шалгаруулалтын орчин үеийн чиг хандлагыг нэвтрүүлэх, нийгмийн хэрэгцээ, шаардлагаас үүдсэн практикт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам"-ыг нэгтгэн, “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам” болгон шинэчлэн баталлаа.

### 3.1. Төрийн албаны ерөнхий шалгалт

Төрийн албаны тухай хуульд<sup>3</sup> заасны дагуу төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй иргэнийг сонгон шалгаруулж, төрийн албан хаагчийн нөөц бүрдүүлэх шалгалтыг 2023 онд 4 удаа зохион байгууллаа.

Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтад давхардсан дүнгээр 16085 иргэн бүртгэгдсэнээс **12683** буюу 78.8 хувь нь шалгалтад оролцож, **5212** иргэн буюу 41.1 хувь нь тэнцэн, төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцөд бүртгэгдэв.

#### *Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтын тоон мэдээлэл*

Улирал	Бүртгэлд хамрагдсан иргэдийн тоо	Шалгалтад оролцсон иргэдийн тоо	Нөөцөд бүртгэгдсэн иргэдийн тоо	Хувь
I	5126	4279	1409	33.3%
II	3816	2975	1430	48.0%
III	3491	2700	1168	43.5%
IV	3652	2729	1205	44.2%
Нийт	16085	12683	5212	41.1%

<sup>3</sup> Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7. “Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

*Ерөнхий шалгалтад оролцогсдын нас, хүйс*

Улирал		нийт	Насны ангиллаар					Хүйсээр	
			25 хүртэлх	26-30	31-35	36-40	40 ба түүнээс дээш	эр	эм
I	бүртгүүлсэн	5126	1214	1228	946	748	990	1777	3349
	тэнцсэн	1409	329	299	329	221	231	412	997
II	бүртгүүлсэн	3816	837	965	866	574	574	1199	2617
	тэнцсэн	1430	317	340	336	224	213	397	1033
III	бүртгүүлсэн	3491	1157	761	603	470	500	1044	2447
	тэнцсэн	1168	392	234	195	178	169	281	887
IV	бүртгүүлсэн	3652	1130	711	815	524	472	1156	2496
	тэнцсэн	1205	343	266	215	168	213	334	871
Нийт	<b>Бүртгүүлсэн</b>	<b>16085</b>	<b>4338</b>	<b>3665</b>	<b>3230</b>	<b>2316</b>	<b>2536</b>	<b>5176</b>	<b>10909</b>
	<b>Тэнцсэн</b>	<b>5212</b>	<b>1381</b>	<b>1139</b>	<b>1075</b>	<b>791</b>	<b>826</b>	<b>1424</b>	<b>3788</b>

*Ерөнхий шалгалтын онооны ангилал*

№	Онооны ангилал	Тэнцсэн иргэдийн тоо
1	96 ба түүнээс дээш	159
2	91-95	438
3	86-90	646
4	81-85	971
5	76-80	1180
6	71-75	1130
7	70 хүртэлх	688
<b>Нийт</b>		<b>5212</b>

Төрийн албаны ерөнхий шалгалтыг улирал тутам зохион байгуулснаар төрийн албаны сул орон нөхөх, шалгалт өгөхөөр хүлээж буй иргэдийн хүлээлт, санал багасаж, үр дүнгээ өгч байна.

Аймаг, нийслэл дэх хүний нөөц бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хүсэлтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны “Байгаль хамгаалагч”-ийн албан тушаалд 60, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Сумдын мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн улсын байцаагч, тархвар зүйч”-ийн албан тушаалд 75, нийт 135 иргэдээс захиалгат ерөнхий шалгалтыг авч, тухайн орон нутаг дахь албан тушаалын сул орон тоог нөхөх боломжийг бүрдүүлэв.

Тайлант онд хуваарьт болон захиалгат ерөнхий шалгалтыг анх удаа зохион байгуулж, хөнгөрүүлсэн босго оноогоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дүгнэж шалгалт өгөх нөхцөл бололцоогоор хангасан нь онцлогтой байлаа. Шалгалтад хөгжлийн бэрхшээлтэй нийт 33 иргэн бүртгэгдсэнээс 26 буюу 78.7 хувь нь шалгалтад оролцож нийт 14 иргэн тэнцэж төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэсэн юм.




Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун, С.Цэдэндамба, Ц.Амартөгс, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга нар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар болон төрийн байгууллагын төлөөлөгчид, мөн “Жайка” олон улсын байгууллагын Засаглалын газрын дэд дарга Ямамото Минако нар ерөнхий шалгалтын үйл ажиллагаанд оролцож, бодит дүгнэлт өгсөн.




*Төрийн албаны ерөнхий шалгалтын статистик мэдээлэл /2019-2023 он/*

№	Агуулга	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он				2023 он /нийт/	Нийт /давхардсан дүнгээр/
						I улирал	II улирал	III улирал	IV улирал		
	Төрийн албаны ерөнхий шалгалтад бүртгүүлсэн иргэдийн тоо	8894	16218	22299	13559	5126	3816	3491	3652	16085	68161
	Төрийн албаны ерөнхий шалгалт өгсөн хүний тоо	7616	12286	17292	11180	4279	2975	2700	2729	12683	53441
	Шалгалтад тэнцж нөөцөд бүртгэгдсэн хүмүүсийн тоо, хувь	1116 /14.6%/	3823 /31.1%/	5484 /31.7%/	3739 /33.4%/	1409 /33.0%/	1430 /48.0%/	1168 /43.5%/	1205 /44.2%/	5212 /41.1%/	18258 /34.2%/
Үүнээс	Ерөнхий мэдлэгийн шалгалтад тэнцсэн хүний тоо	1588	5017	7343	4991	1915	1747	1468	1471	6601	23952
	Монгол хэл бичгийн чадварын шалгалтад тэнцсэн хүний тоо	1443	4070	5858	3944	1497	1492	1216	1262	5467	19339
	Дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад тэнцсэн хүний тоо	1116	3823	5484	3739	1409	1430	1168	1205	5212	18258





Төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцийн ашиглалт  
/2020-2023 он/



Төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцийн ашиглалт 38.3 хувь буюу 6997 иргэн төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон байна.

Төрийн албаны ерөнхий шалгалт бүрэн цахимжиж, техник технологийн шийдлийг нэвтрүүлснээр хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бус, ил тод нээлттэй явагддаг, шалгалтын дүн зөвхөн хувь хүнээс хамаарна гэдэг нь нотлогдож хэвшив. Төрийн албаны ерөнхий шалгалт нь аливаа өргөдөл, гомдол, маргаангүй байгаа нь нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, иргэдийн итгэл нэмэгдсэнийг харуулж байна.

### 3.2. Төрийн албаны тусгай шалгалт

Тайлант онд төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 10372 сул орон тоог нөхөх тусгай шалгалт буюу сонгон шалгаруулалт зарласнаас **4316** албан тушаалд **6391** иргэн өрсөлдлөө. Хамгийн өндөр авсан **4316** иргэнийг тус тусын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн.

Сонгон шалгаруулалт				Сул орон тоо		
Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын зарласан сул орон тоо	Бүртгүүлэх			Шалгалтад оролцсон хүн	Нэр дэвшсэн сул орон тоо	Нөхөгдөөгүй сул орон тоо
	Хүсэлт өгсөн	Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй			
<b>10372</b>	<b>11335</b>	<b>7492</b>	<b>3843</b>	<b>6391</b>	<b>4316</b>	<b>6056</b>

*Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байдал*

№	Сонгон шалгаруулалт зохион байгуулсан байгууллага	Зарласан сул орон тоо	Нэр дэвшсэн сул орон тоо	Нөхөгдөөгүй сул орон тоо
1	Төрийн албаны зөвлөл	422	341	81
2	Төрийн албаны зөвлөлийн Яамдын дэргэдэх салбар зөвлөл	1041	730	311
3	Төрийн албаны зөвлөлийн Агентлагуудын дэргэдэх салбар зөвлөл	836	668	168
4	Төрийн албаны зөвлөлийн Аймаг, нийслэлийн салбар зөвлөл	8073	2577	5496
<b>Нийт</b>		<b>10372</b>	<b>4316</b>	<b>6056</b>

*Нөхөгдсөн орон тоог түшмэлийн ангиллаар харуулбал*

Түшмэлийн ангилал	Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	Нийт
Тэргүүн	31	2	33
Эрхэлсэн	128	58	186
Ахлах	294	219	513
Дэс	117	3193	3310
Туслах	-	274	274
<b>Нийт</b>	<b>570</b>	<b>3746</b>	<b>4316</b>

2023 онд төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 4316 сул орон тоо нөхөгдсөнөөс тэргүүн түшмэлийн албан тушаалд 33, эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 186, ахлах түшмэлийн албан тушаалд 513, дэс түшмэлийн албан тушаалд 3310, туслах түшмэлийн албан тушаалд 274 иргэн байна.


*Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд сонгон шалгаруулалтаар нөөцөөс нөхөгдсөн байдал*

Төрийн албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэдийн нөөц				Төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөц	Төрийн албанаас чөлөөлөгдсөн албан хаагч болон иргэний нөөц	Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад орж тэнцсэн иргэний нөөц
2020 он	2021 он	2022 он	2023 он			
349	640	839	1347	<b>803 буюу 18.6%</b>	<b>334 буюу 7.7%</b>	<b>4 буюу 0.09%</b>
<b>3175 буюу 73.6 %</b>						

Тайлант онд нийт нөхөгдсөн удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 4316 сул орон тооны 803 нь төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөцөөс, 334 нь төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэний нөөцөөс, 4 нь төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад орж тэнцсэн иргэний нөөцөөс, 3175 нь

төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэдийн нөөцөөс тус тус нөхөгдсөн байна.

Нэр дэвшүүлсэн иргэдийн 92.6 хувь буюу 3998 нь тухайн албан тушаалдаа томилогдон ажиллаж байна.



Нэр дэвшсэн иргэдийн 1372 нь эрэгтэй, 2944 нь эмэгтэй байна.

### Өмнөх онтой харьцуулбал



Төрийн захиргааны удирдах албан тушаалын 969 сул орон тооны сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад 570 буюу 59.0 хувь нь, гүйцэтгэх албан тушаалын 9403 сул орон тооны сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад 3746 буюу 40.0 хувь нь тус тус нөхөгдсөн байна. Өмнөх онтой харьцуулахад удирдах албан тушаалын сул орон тоо нь 15, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нь 796 буюу нийт 811 сул орон тоогоор нэмэгдэж нөхөгдсөн үзүүлэлттэй байна.


### Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалт

Тайлант онд төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 431 албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтыг зарлаж, сонгон шалгаруулалтад давхардсан тоогоор 1119 иргэн хүсэлт өгч, 680 иргэн шаардлага хангаснаас шалгалтад 632 иргэн оролцож, 266 иргэн буюу 42.1 хувь нь тэнцэж, зарлагдсан сул орон тооны **62.0** хувь нь нөхөгдсөн үзүүлэлттэй байна.

*Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн  
сул орон тооны сонгон шалгаруулалт*

№	Зохион байгуулсан байгууллага	Зарласан	Нөхөгдсөн	Нөхөгдөөгүй
1	Аймаг, нийслэлийн салбар зөвлөл	371	238	133
2	Боловсрол, шинжлэх ухааны яамны дэргэдэх салбар зөвлөл	36	16	20
3	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх салбар зөвлөл	1	0	1
4	Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөл	3	0	3
5	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөл	12	9	3
6	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөл	3	1	2
7	Соёлын яамны дэргэдэх салбар зөвлөл	5	2	3
<b>Нийт дүн</b>		<b>431</b>	<b>266</b>	<b>165</b>

*Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн  
сул орон тоо нөхсөн байдлыг өмнөх онтой харьцуулбал*




Тайлант онд төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 266 сул орон тоо нөхөгдсөн өмнөх оныхоос 40 сул орон тоогоор нэмэгдэж нөхөгдсөн үзүүлэлттэй байна.

**Хүний нөөцийн шинэтгэл, сонгон шалгаруулалтын үр дүнд суурилсан,  
төрийн албаны мерит зарчмыг бэхжүүлэх талаар**

“Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй хамтран төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтан, хүний нөөцийн мэргэжилтэн, сонгон шалгаруулалтын комиссын гишүүдэд зориулж “Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулах гишүүдэд зориулсан, тусгай шалгалтын ярилцлагыг зохион байгуулах зөвлөмж” гарын авлагыг бэлтгэн гаргаж, “Чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага буюу чиг үүргүүдийн уялдаа холбоо, ач холбогдол” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 132 албан хаагч оролцсон.

Сургалтаар сонгон шалгаруулалтын олон улсын туршлагыг танилцуулж Санхүү эдийн засгийн их сургуулийн Салбар дундын тэнхимийн эрдэмтэн, багш, судлаачид Герман, БНХАУ, Япон, Солонгос зэрэг улс орнуудын төрийн албаны сонгон шалгаруулалт, ерөнхий шалгалтын тогтолцоо, сорилын арга хэлбэрт харьцуулсан судалгааны үр дүн, мэдээллийг хуваалцав.



## Төрийн албаны шалгалт ба төрийн өмчит аж ахуйн тооцоот байгууллага, хувийн хэвшлийн оролцоо

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2023 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 07/04 тоот тушаалаар “Эрдэнэс Монгол” ХХК-аас нээлттэй зарласан ажлын байрны уралдаант шалгаруулалтын “Тест-сорилын шалгалтыг цахимаар зохион байгуулах үүрэг бүхий комиссын нарийн бичгийн дарга болон зарласан нээлттэй ажлын байрны сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн нэр дэвшигчдийн баримт бичгийн бүрдүүлэлтийг хянан шалгах, баталгаажуулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг арга зүйн удирдлагаар хангаж ажилласан. Энэ нь төрийн албаны шалгалтыг төрийн өмчит аж ахуйн тооцоот байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд хүлээн зөвшөөрдөг боллоо.

<p><b>"Эрдэнэс Монгол" ХХК-д ажилд орохоор 82 доктор бүртгүүлжээ</b></p> <p>"Эрдэнэс Монгол" ХХК-аас зарласан ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтын бүртгэлийн талаар мэдээлж байна.</p> <p>42 2023-01-16 11:07</p>	<p><b>"Эрдэнэс Монгол"-ын хүний нөөцийн сонгон шалгаруулалтын үеэр зөрчил гараагүй</b></p> <p>"Эрдэнэс Монгол" ХХК-ийн ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтын сорилын шалгалт үргэлжилж байна. Шалгалтын явцын талаар мэдээлэл өгч</p> <p>16 2023-01-27 16:42</p>
<p><b>"Эрдэнэс Монгол" ХХК-ийн 88 ажлын байранд 693 хүн бүртгүүлээд байна</b></p> <p>Төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК-д чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор гүйцэтгэх захирлаас бусад 88 ажлын байрны сонгон шалгаруулалтыг</p> <p>25 2023-01-03 10:44</p>	<p><b>"Эрдэнэс Монгол"-ын ажилчдыг сонгох төстийн шалгалт хоёр дахь өдрөө үргэлжилж байна</b></p> <p>"Эрдэнэс Монгол" компанийн хүний нөөцийг нээлттэй сонгон шалгаруулах шалгалт Д.Нацагдоржийн нэрэмжит Нийслэлийн төв номын санд хоёр дахь</p> <p>1 2023-01-27 10:21</p>
<p><b>"Эрдэнэс Монгол"-ын ажлын байрны бүртгэл өнөөдрөөс эхэллээ</b></p> <p>Төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК-д чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор гүйцэтгэх захирлаас бусад 88 ажлын байрны сонгон шалгаруулалтыг</p> <p>72 2023-01-02 11:00</p>	<p><b>"Эрдэнэс Монгол"-ын сонгон шалгаруулалтын эхний гурван шалгалтын байдлаар ирц 70 хувьтай байна</b></p> <p>"Эрдэнэс Монгол" компанийн хүний нөөцийг нээлттэй сонгон шалгаруулах шалгалт Нийслэлийн төв номын санд үргэлжилж байна. Шалгалт өглөө 08.30-д</p> <p>33 2023-01-26 20:09</p>
<p><b>Д.Амарбаясгалан: "Эрдэнэс Монгол" ХК-ийн ахлах менежер 9-12 сая төгрөгийн цалин авна</b></p> <p>"Эрдэнэс Монгол" ХК-ийн 88 ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтын талаар ЗГХЗГ-ын дарга Д.Амарбаясгалан мэдээлэл хийж байна.</p> <p>44 2022-12-30 11:34</p>	<p><b>"Эрдэнэс Монгол" ХХК-д ажиллах иргэдийг нээлттэй сонгон шалгаруулах гурав дахь шалгалт үргэлжилж байна</b></p> <p>"Эрдэнэс Монгол" ХХК-д ажиллах иргэдийг нээлттэй сонгон шалгаруулах шалгалт Нийслэлийн төв номын санд эхэллээ.</p> <p>17 2023-01-26 14:01</p>
<p><b>"Эрдэнэс Монгол" ХК-ийн 88 ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт явуулна"</b></p> <p>Засгийн газрын хуралдааны шийдвэрийг танилцуулж байна.</p> <p>27 2022-12-23 11:23</p>	<p><b>"Эрдэнэс Монгол" ХХК-ийн ажлын байрны сонгон шалгаруулалтын шалгалтад 2407 хүн орно</b></p> <p>"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Нээлттэй болон нөөц бүрдүүлэх ажлын байрны сонгон шалгаруулалтын явцын талаар мэдээлэл хийжээ. Төрийн ордын Нутгийн</p> <p>5 2023-01-24 13:09</p>

## ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ САХИУЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн албаны тухай хуульд төрийн улс төрийн болон төрийн тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор, төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг Засгийн газар тогтоохоор хуульчилж, энэ хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн харилцааг ерөнхий зохицуулалттай болон салбарын 42 хууль<sup>4</sup>, 35 ёс зүйн дүрэм, журмаар зохицуулж байсан.

Ёс зүйн зөрчлийн 2023 оны хагас жилийн байдлаар 389 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргаснаас төрийн захиргааны албан тушаалтан 159, төрийн үйлчилгээний албан тушаалтан 230 байна. Ёс зүйн зөрчлийн тоог өмнөх онтой харьцуулахад 26-аар буурсан үзүүлэлт гарч байна.



Ёс зүйн зөрчлийг агуулгаар нь авч үзвэл, ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн болон ажлын хариуцлага алдсан 93, албан үүргээ гүйцэтгэх явцдаа болон ажлын байранд архидан согтуурсан 34, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй 16, ажлын цаг ашиглалтын 28, харилцаа, хандлагын 178, бусад буюу нууц задруулах, захирах захирагдах ёсыг зөрчих, албаны нэр барих, байгууллагын эд хөрөнгийг хувийн зорилгоор ашигласан зэрэг 40 зөрчил тус тус гарлаа.

Ёс зүйн зөрчлийг шалгаж төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад зохих хариуцлага ногдуулсны 161 нь сануулах, 97 нь уучлал гуйхыг үүрэг болгосон хариуцлага хүлээлгэж, 21 нь сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдсөн бөгөөд 110 тохиолдлыг ёс зүйн хариуцлага тооцох үндэслэлгүй гэж үзсэн байна.

### Ёс зүйн зөрчлийн тоон үзүүлэлт

№	Утга	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Нийт	
1	Ёс зүйн зөвлөл байгуулагдсан /төрийн захиргаа, үйлчилгээ/	-	1194	1517	250	-	2961	
2	Ёс зүйн зөрчлийн тоо	637	613	419	415	389	2473	
3	Ёс зүйн зөрчилд хүлээлгэсэн хариуцлага	Сануулсан	327	465	248	255	161	1456
		Уучлал гуйхыг үүрэг болгосон	44	131	168	149	97	589
		Сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдсөн	11	17	3	0	21	52
		Хариуцлага тооцох үндэслэлгүй гэж үзсэн	33	0	0	11	110	154

<sup>4</sup> “Төрийн албан хаагчийн ёс суртахууны эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ” судалгааны тайлан., Удирдлагын академи., 2023 он

3	Ёс зүйн зөрчил үйлдсэн төрийн албан хаагч	Төрийн захиргааны албан хаагч	316	353	150	221	159	1199
		Төрийн үйлчилгээний албан хаагч	321	260	269	194	230	1274
4	Ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан сургалт, соён гэгээрүүлэх ажилд хамрагдсан албан хаагчийн тоо		1400	23840	14500	40835	27045	107620

*Ёс зүйн зөрчлийг агуулаар*

№	Агуулга	2019	2020	2021	2022	2023 он	Нийт
1	Ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн	135	196	35	19	93	478
2	Албан үүргээ гүйцэтгэх явцдаа болон ажлын байранд архидан согтуурсан	98	37	75	153	34	397
3	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй	87	48	42	25	16	218
4	Ажлын цаг ашиглалтын зөрчил	85	61	26	57	28	257
5	Харилцаа, хандлагын зөрчил	177	163	126	158	178	802
6	Бусад/захирах захирагдах ёс зөрчих, байгууллагын эд хөрөнгийг хувийн зорилгод ашиглах гэх мэт/	55	108	115	3	40	321
<b>Нийт:</b>		<b>637</b>	<b>613</b>	<b>419</b>	<b>415</b>	<b>389</b>	<b>2473</b>

Монгол Улсын төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоож, ёс зүйн асуудлыг эрхлэх бүтэц, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийг Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдөр баталж, 7 дугаар сарын 03-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус Зөвлөлийн гишүүд болон холбогдох албан хаагчид орж, хуулиар зохицуулах харилцаа, төрийн байгууллагын Ёс зүйн дэд хорооны эрх зүйн зохицуулалт, бусад асуудлаар зохих дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын Байнгын хороотой хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөлд санал авах ажлыг улсын хэмжээнд 2, орон нутгийн хэмжээнд 9, нийт 11 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал, яам, агентлаг, УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллагын удирдлага, төрийн албан хаагчийн төлөөлөл, эрдэмтэн судлаач, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл, орон нутгийн төрийн албан хаагчийн хүрээнд зохион байгууллаа.



Шинээр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг зөв ойлгож хэрэглэх, байгууллагын соёл, дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбоотой сургалт, Ёс зүйн дэд хороог байгуулах, мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах ажлыг орон нутаг, нийслэл, яам, агентлагийн түвшинд зохион байгуулж, яам, агентлаг, аймаг, дүүргийн нийт 368 төрийн байгууллагын давхардсан тоогоор 22000 гаруй төрийн албан хаагч хамрагдлаа.



Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдаж, Төрийн албаны зөвлөлийн дэргэд “Ёс зүйн хороо” байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр Ёс зүйн хороо холбогдох дүрэм, журмыг боловсруулах, баталж мөрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.



### 5.1. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, урамшуулал

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”-д төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагчийн цалинг инфляцын түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх зорилт тусгагдсаны дагуу Засгийн газраас Төрийн албаны цалин хөлсний бүтэц, цалингийн тогтолцооны шинэтгэл үе шаттайгаар хэрэгжиж, бодит үр дүн гарч байна.

Улсын Их Хурал, Засгийн газар, яамдаас боловсруулж санал авахаар ирүүлсэн 11 тогтоолын төсөлд төрийн албаны цалингийн нэгдсэн тогтолцооны шинэчлэл, цалин хөлсийг ажилласан жил, үр дүн, бүтээмжтэй уялдуулах зорилтыг бүрэн дэмжиж, төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан, төрийн албаны албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлсийг боловсронгуй болгох чиглэлээр санал гаргаж ажиллалаа.

Засгийн газраас нийт 217.0 мянга орчим төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, зарим цалингийн ялгааг арилгаж суурийг нэмэгдүүлэх, нэг ангилалтай болгож үндсэн цалингийн доод хэмжээг нэмэгдүүлэх шинэтгэлийг хэрэгжүүлж, үүнээс төрийн мэргэжлийн үйлчилгээний 93.2 мянга, төрийн нийтлэг үйлчилгээний 58.9 мянга, төрийн захиргааны 23.0 мянга, соёл урлаг, биеийн тамир, спортын 2.6 сая, төрийн тусгай 350. мянга, төрийн улс төрийн 3.8 мянган төрийн албан хаагчийн цалин 10-50 хувиар нэмэгдүүлж, 986.6 тэрбум төгрөгийг төлөвлөж улсын төсвийн тодотголоор баталснаар Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол батлагдан, 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөнөөр төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хангагдах нөхцөл бүрдэн, үр нөлөөг дээшлүүлсэн.

Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог, Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг 11 байгууллагын Ажлын албаны батлагдсан бүтэц, орон тоо, цалингийн сан тус бүрээр дүн шинжилгээ хийснээр сүүлийн жилүүдэд цалин нэмэгдээгүй нийт 900 орчим төрийн албан хаагчийн цалинд шаардагдах төсөв, хөрөнгийн тооцоолол, танилцуулгыг тогтоолын төслийн хамт бэлтгэж УИХ, Засгийн газар, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэн, зохион байгуулснаар бодит арга хэмжээ болж, цалинг 40 орчим хувиар нэмэгдүүлж, төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хангах нөхцөл бүрдсэн.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль батлагдахтай холбогдуулан төрийн албан хаагчийн цалин хөлсний чиглэлээр төсөвт тусгаж буй асуудлууд, нэмэлт өөрчлөлтийн талаар холбогдох мэдээлэл, эдийн засгийн зарим үзүүлэлт (улсын дундаж цалингийн өсөлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлт, амьжиргааны баталгаажих доод түвшний өсөлт)-ийн өсөлттэй уялдуулан цалин нэмэгдлийн зарим тооцооллыг бэлтгэн, төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны талаар тодорхой санал дүгнэлт гарган ажиллаж байна.


Засгийн газрын захиалгаар Удирдлагын академиас хэрэгжүүлсэн “Төрийн захиргааны албан хаагчийн цалин, урамшууллын тогтолцооны өнөөгийн байдал, түүнийг оновчтой болгох нь” сэдэвт судалгааны ажилд хамтран ажиллалаа.

Төрийн албаны шинэтгэлийн “Цалингийн нэгдсэн тогтолцооны шинэчлэл”-ийн хүрээнд өмнө хийгдсэн нийт 190,000 төрийн албан хаагчийн цалин хөлсний мэдээлэл цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, тусламж, нөхөн төлбөр, тэтгэмж, тэтгэлэг, бусад үзүүлэлт бүхий эдийн засгийн ангиллаар төв, орон нутгийн бүх Төсвийн Ерөнхийлөн Захирагчдаар, төрийн байгууллагуудаар, төрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, төрлөөр, цаг хугацааны хувьд оны үечлэлтэйгээр Сангийн яамны Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн сангаас татуулж, өмнө гаргаж байсан 30 гаруй үзүүлэлтээр, 10 орчим хувилбараар нэгтгэл, боловсруулалт, дата шинжилгээ хийж үүсгэсэн мэдээллийн санг шинэчиллээ.

Цалин хөлс, ангилал зэрэглэл, нэмэгдлийн талаар хандсан ойролцоогоор давхардсан тоогоор 100 орчим төв, орон нутгийн төрийн байгууллага, албан хаагчид биечлэн болон цахимаар, утсаар арга зүйн зөвлөмж өгч, мэдээллээр хангаж ажилласан байна.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор төрийн албаны албан тушаалын ангилал хооронд ур чадварын шилжилт хийх эрх зүйн үндэс бүрдсэн. Хуулийн өөрчлөлтийн дагуу Төрийн албаны зөвлөл өмнөх онуудад батлагдсан 55 дүрэм, журамд шинэчлэл хийж хууль, дүрэм, журмыг таниулах “Ур чадварын шилжилт” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн аймаг, нийслэл дэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, албан хаагчдад 2023 оны 3, 4 сард үе шаттайгаар танхимаар зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцох журам”-ын хүрээнд 66 иргэний асуудлыг судлан Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн нийт 64 иргэний ажилласан хугацааг дүйцүүлэн тооцож, баталгаажуулав.



АЖИЛЛАСАН ХУГАЦААГА ДҮЙЦҮҮЛЭН ТООЦУУЛСАН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ


ИД	Овог, нэр	Регистрийн нөмөр	Зохих ангилал	Дүйцүүлэн тооцсон хугацаа
1.	Энэбийн Мөнх-Очир	У970081518	Тэргүүн түшмэл Ахлах түшмэл	02 жил 01 сар 29 хоног 01 жил 08 сар 18 хоног
2.	Шолоодорын Эрдэмтөр	ДН92082817	Тэргүүн түшмэл Эрхэлсэн түшмэл	02 жил 01 сар 07 хоног 04 жил 06 сар 06 хоног
3.	Лугдасүрэнгийн Дэлгэр	УСТ9030653	Эрхэлсэн түшмэл	05 жил 02 сар 16 хоног
4.	Батсүх Эрдэнэбайр	УХ77040517	Эрхэлсэн түшмэл	03 жил 11 сар 13 хоног
5.	Батбаяр Гантулга	ТЭ7002891	Эрхэлсэн түшмэл	03 жил 04 сар 26 хоног
6.	Чойрзоригийн Уранчимэг	ГМ7001603	Эрхэлсэн түшмэл	2 жил 02 сар 17 хоног
7.	Тэгшдамсгийн Очирсайхан	Р975050701	Ахлах түшмэл	01 жил 06 сар 29 хоног
8.	Уртнасангийн Батсүхмөнх	БД04102712	Ахлах түшмэл	02 жил 02 сар 02 хоног

Төрийн үйлчилгээний удирдах болон төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх асуудлыг судлан, төрийн захиргааны албан тушаалд адилтган авч үзэх албан тушаалуудын жагсаалтыг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, 2023 оны 34, 26 дугаар тогтоолуудаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуулиар хүлээсэн үүргээ ёс зүйтэй, хариуцлагатай биелүүлж төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэхэд манлайлан ажиллаж буй нийт 174 албан хаагчийг “Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдэг”-ээр шагнах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Тайлант онд төрийн захиргааны тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгуулахаар төрийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн 233 саналыг судалж, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасан тусгай шаардлагын дагуу Төрийн албаны зөвлөлийн 5 удаагийн хуралдаанаар хэлэлцэн, эрх бүхий байгууллагад уламжлан хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны зарлигаар 32 төрийн захиргааны албан тушаалтанд тэргүүн түшмэлийн зэрэг дэв, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны захирамжаар 236 төрийн захиргааны албан тушаалтанд эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгож, улсын хэмжээнд 2019-2023 онд төрийн захиргааны нийт 780 албан хаагчид тэргүүн 106, эрхэлсэн 674 зэрэг дэв олгосон байна.



Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл холбогдох төрийн захиргааны төв байгууллага хамтран төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах, тодорхой салбар, төрийн үйлчилгээнд чиглэсэн нэгдсэн бодлого хэрэгжүүлж ажилласны үр дүнд 2023 онд төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангах зорилгод ахиц гарсан гэж үзэж байна. Мэргэшсэн, чадварлаг төрийн албан хаагчийн төрийн алба хооронд шилжүүлэн ажиллуулах, ур чадварын шилжилт хийх, хүний нөөцийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн.

“Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын албан хаагчийн цалин хөлс, түүнийг инфляцын түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулах нь”, “Төрийн захиргааны албан хаагчийн цалин, урамшууллын тогтолцооны өнөөгийн байдал, түүнийг оновчтой болгох нь” зэрэг судалгааг хийж, төрийн байгууллагуудын цалин хөлсний ялгаатай байдлыг тогтоон, өнөөгийн түвшинд мөрдөгдөж байгаа цалин хөлс, урамшууллын тогтолцоо нь олон улсын хөдөлмөрийн харилцааны үндсэн зарчим, ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэх арга аргачлалд тулгуурласан, үнэн зөв, шударга байх тогтолцоог бүрдүүлж чадахгүй байгааг тодорхойлж, цалин хөлсний бодлогыг хэрэгжүүлж буй холбогдох байгууллагад санал хүргүүлж ажилласны үр дүнд төрийн албан хаагчийн цалин хөлсний ялгаатай байдлыг арилгах, цалин хөлсний нэгдсэн тогтолцоог бий болгох нөхцөл, боломж бүрдсэн.

## 5.2. Чадахуйн зарчмын хэрэгжилтэд хийсэн хүний нөөцийн аудит

Төрийн албаны тухай хууль тогтоомж, чадахуйн зарчмын хэрэгжилтэд хүний нөөцийн аудит хийх чиглэлээр Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 2023 онд хэрэгжүүлэх “Хүний нөөцийн аудитын сэдэв, төлөвлөгөө”-г баталсан.

“Чадахуйн зарчмын хэрэгжилт-Төрийн захиргааны албан хаагчийн ур чадвар, туршлагын шаардлагын нийцэл” сэдвийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар дахь төрийн албаны төрийн захиргааны албан тушаалтнуудын туршлага, ур чадварын шаардлагын нийцлийг тодорхойлох зорилгоор Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар, Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд 176 албан хаагчийг хамруулан хүний нөөцийн аудит хийв.

Ур чадварын оноо	2021-2022	2023	Зөрүү
Удирдах	65,4%	66,5%	1,1%
Гүйцэтгэх	49,2%	60,3%	11,1%

Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй хамтран хүний нөөцийн аудитор бэлтгэх багц цагийн хөтөлбөртэй, кредит тооцох сургалтыг 2023 оны 5 дугаар сард зохион байгуулж яам, агентлаг, нийслэл, зарим аймгийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүн, хүний нөөцийн ажилтны төлөөлөл нийт 40 албан хаагчийг хамруулж, хүний нөөцийн аудиторын гэрчилгээ олгосноор төрийн албаны хүний нөөцийн мэргэшсэн аудитор бэлтгэх эхлэл тавигдлаа.



“Чадахуйн зарчмын хэрэгжилт-Төрийн захиргааны албан хаагчийн ур чадвар, туршлагын шаардлагын нийцэл” сэдвийн хүрээнд хийсэн аудитаар тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн албан тушаалд томилогдон ажиллаж байгаа албан хаагчийн 11.4 хувь нь туршлагын шаардлагыг хангахгүй байгаа нь төрийн жинхэнэ албан тушаалд хууль журамд заасан шалгуурыг хангасан албан хаагчийг сонгон шалгаруулалтаар томилох үйл ажиллагаа хангалтгүй, шаардлага хангаагүй албан хаагчдыг томилж, албан хаагчийг тэгш өрсөлдөх боломжоор хангахгүй, чадахуйн зарчмыг хэрэгжүүлээгүй байна. Аудитад хамрагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн 2023 оны ур чадварын үнэлгээг 2022 онтой харьцуулахад удирдах ажилтны ур чадвар 1,1%-иар, гүйцэтгэх ажилтны ур чадвар 11.1%-иар өссөн үзүүлэлттэй байгаа нь аудитад хамрагдсан салбар албан хаагчийнхаа ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн боловч ур чадварын үнэлгээ бодиттой

эсэхийг үнэлэх боломжгүй, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад шинжилгээ хийж бүтцийг оновчтой тогтоох шаардлагатай байгаагийн илрэл юм.

### 5.3. Сургалт, нөлөөллийн болон зөвлөн туслах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ

Тайлант хугацаанд чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага, чадамжийн хүрээний баримт бичиг, албан тушаалын тодорхойлолтод болон гүйцэтгэлийн удирдлагад чадамжийн хүрээг ашиглах, харилцан уялдаатай хамтран ажиллах, ур чадварын шилжилт, цахимжилт, хүний нөөцийн аудит хийх аргачлал, үр дүн, төрийн албаны манлайлал, үнэт зүйл гэсэн өргөн цар хүрээ, агуулга бүхий сэдвээр сургалт, нөлөөллийн болон зөвлөн туслах ажлуудыг зохион байгууллаа.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлэх, судалгаа, шинжилгээний ажлыг төрийн албаны сургалтын байгууллага болон эрдэмтэн судлаачидтай хамтран хэрэгжүүлж, төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих орчин бүрдүүлэх эхлэлийг тавьж, үр дүнд хүрч байна.

Төрийн албаны зөвлөлөөс 2023 оны 1 дүгээр сард нийт 170 гаруй удирдах болон хүний нөөцийн ажилтнууд оролцсон цахим уулзалтыг зохион байгуулж, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэл дууссантай холбогдуулан тус хуулийн хүрээнд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлгүй, сонгон шалгаруулалтгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шалгалтыг хангаагүй томилогдсон албан хаагчдыг албан үүргээс чөлөөлөх, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх талаар “Зөвлөмж”-ийг танилцуулж, хүргүүлэн ажилласны дүнд төрийн албаны сул орон тоог нөхөх үйл ажиллагаа эрчимжсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2023 оны 05, 81 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг Гаалийн ерөнхий газар, түүний харьяа 15 газар, 3 хороо, Баян-Өлгий, Ховд аймгийн нутгийн захиргааны 45 байгууллагын удирдлага, хүний нөөцийн ажилтнуудад албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн удирдлагад чадамжийн хүрээг ашиглах, чадамжид суурилсан хүний нөөцийг бүрдүүлэх талаар “Төрийн албаны манлайлал, үнэт зүйл” сэдвээр сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 902 төрийн захиргааны албан хаагчид оролцов.



Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Төрийн албаны зөвлөл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй хамтран аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга нар, бусад 52 төлөөлөлд зориулан 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр “Төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйн өөрчлөлт бүтээмжид нөлөөлөх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.




Мерит төсөлтэй хамтран 2023 онд Сүхбаатар аймагт “Жендерийн мэргэжилтэн манлайлагчдын чуулга уулзалт” зохион байгуулж жендерийн бие даасан мэргэжилтний хэрэгцээ ба түүний албан тушаалын тодорхойлолтын талаар мэдээлэл өгч, хэлэлцүүлэв.




Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд төрийн албан хаагчийн сургалтын модулийг хөгжүүлэн ашиглалтад оруулж, 25 байгууллагад туршилтыг эхлүүлэв.

Цахим сургалтын модуль нь төрийн захиргааны албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хувь хүний карьер хөгжлийн төлөвлөлт, сургалтын хэрэгцээнд үндэслэж, оролцогч талуудын мэдээлэл солилцох урсгалыг бий болгож, сургалтын тэгш, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэн, шатлан дэвшүүлэх тогтолцоог бэхжүүлэх ач холбогдолтой хөгжүүлэлт болсон.



ХНУМТ цахим системийн сургалтын модулийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академийн сургалтын системтэй интеграци хийж, сургалтын нэгдмэл, нээлттэй, тасралтгүй, оновчтой, хурдтай, хариуцлагатай, сонголттой, хамтын, мэргэжлийн зарчмыг хэрэгжүүлэх ач холбогдолтой юм.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Удирдлагын академийн сургалтын систем, Төрийн албаны зөвлөлийн ХНУМТ цахим системийн интеграци, нэгдмэл байдлыг цаашид үргэлжлүүлэхээр хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.



Төрийн албаны зөвлөл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй хамтран “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын зарим асуудал” сургалт, хэлэлцүүлгийг 2023 оны 02, 5, 12 дугаар сард яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагийн дарга, УИХ-ын харьяа байгууллагын дарга, 21

аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт, “Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр”-ийн үр дүн, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хөтөлбөрийн ментор болон төгсөгчдийн оролцоотой санал солилцох уулзалт, хэлэлцүүлгийг тус тус хийв.

Төрийн албаны зөвлөл, MERIT төслийн баг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр хийж буй үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл хийж, Жендерийн эрх тэгш байдлыг хангах хууль, түүний хэрэгжилт, үр дүнгийн талаар санал солилцож, төслийн техникийн зөвлөх Дуглас Армор яам бүрд байдаг жендер хариуцсан мэргэжилтэн, Жендерийн зөвлөлийн үүрэг хариуцлага, үр нөлөөг эргэн харах шаардлагатай байгааг дурдаад, яамдын Жендерийн зөвлөлүүд нь тухайн салбар, орон нутаг, тэр дундаа аймгийн хэмжээнд төлөөлөлтэй байх, зөвлөлийн гишүүдийг сонгохдоо тэдний Жендерийн тэгш байдлын мэдлэг туршлагыг харгалзах, үүрэг хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлага байгааг тэмдэглэв.

### **Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” арга зүйн сургалт, мэдээлэл**

Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сургалтыг тасралтгүй явуулж, зохион байгуулах, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “7:4:10” арга зүйн вебинар сургалтыг 7 хоног бүрийн Пүрэв гарагт уламжлал болгон тогтмол зохион байгуулж хэвшээд байна.


Тус сургалтад 2021, 2022 онд 56 удаагийн /69 цаг/ сургалтад нийт 99000 хэрэглэгчийн эрхээр 150.000 гаруй төрийн албан хаагч хамрагдсан. 2023 онд нийт 71238 хэрэглэгчийн

эрхээр 90.000 гаруй төрийн албан хаагч “Стратеги төлөвлөлт”, “Бодлого, шийдвэр”, “Ёс зүй, манлайлал”, “Харилцаа, хандлага, стресс менежмент”, “Систем, сэтгэлгээ”, “Түүх, соёл” гэсэн 6 агуулгын хүрээнд 24 удаагийн сургалт мэдээлэлд хамрагдлаа.


Сургалтын зочин багшаар олон улс болон өөрийн улс, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, улс төр, нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэн багш, судлаач нар уригдаж, төрийн албан хаагчдад мэдээлэл өгсөн байна.

Төрийн албан хаагчийн дунд хийсэн судалгаагаар оролцогчдын 89.7 хувь нь орон нутгаас, 10.3 хувь нь Улаанбаатар хотод байрлах төрийн байгууллагад ажилладаг албан хаагчид байна.

### Аймгуудын оролцоо



### Нийслэл, дүүргүүдийн оролцоо



Улаанбаатар хотоос оролцогчдын 46.3 хувь нь яам, 40.2 хувь нь Засгийн газрын агентлагийн албан хаагчид, орон нутгаас Өмнөговь, Дорнод, Дархан-Уул, Говь-Алтай аймгуудын төрийн албан хаагчийн оролцоо хамгийн өндөр байна.

### Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц болон дунд хугацааны сургалт


Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэн 2019 оны 1 дүгээр сарын 1-ээс хойших 5 жилийн хугацаанд нийт 78185 төрийн албан хаагч, үүнээс 6896 албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад, 4407 албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны болон давтан сургалтад, 66882 албан хаагч чиглүүлэх болон богино хугацааны сургалтад тус тус хамрагдаж, мэргэшсэн байна.



Төрийн албан тушаал бүрээр мэргэшүүлэх сургалтын тогтолцоо бүрдүүлсэн бөгөөд агуулгыг өргөжүүлж, зайнаас суралцах, дүгнэх, үнэлэх, цахим платформ нэвтрүүлсэн нь ажлын байрандаа суралцах боломж бүрдэв.

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу төрийн захиргааны албан тушаалын тусгай шаардлага, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” 02 дугаар тогтоол, 2023 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 90 дүгээр тогтоолд заасны дагуу албан тушаалын сургалт буюу мэргэшил хэсгийн шаардлага уян хатан зохицуулалттай боллоо.


Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо



Тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад 2023 онд 1385 албан хаагч хамрагдсан байна.


Мэргэшүүлэх багц сургалтын тоон судалгаанаас үзвэл ахлах түшмэлийн албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтын эрэлт хэрэгцээ хамгийн их буюу дөрвөн жилийн дунджаар 1245 төрийн албан хаагч хамрагдаж төгссөн байна. Удирдлагын академиас жилд 6-аас доошгүй удаагийн элсэлтээр сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна.

Мэргэшүүлэх багц болон дунд хугацааны сургалтад хамрагдалтын тоо (2019-2023 он)



Тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны болон дунд хугацааны давтан сургалтад 2019-2023 онд нийт 11303 албан хаагч элсэн суралцсанаас 4507 буюу 39.8 хувь нь орон нутгаас, 6796 буюу 60.1 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна.

2019-2023 онд мэргэшүүлэх сургалтад хамрагдалтын байдал аймагээр



Нийт 11303 элсэгчээс 8818 буюу 78.0 хувь нь тухайн төрлийн сургалтаа төгссөн, 2485 буюу 22.0 хувь нь суралцаж буй төлөвтэй байна. Ийнхүү суралцаж буй төлөвтэй 2485 элсэгчийн хувьд 200 гаруй нь албан байгууллагынхаа хүсэлтээр элссэн боловч төрийн албанд ажиллахгүй, хувийн хэвшлийн байгууллагад шилжсэн нь сургалтын үр дүнд тулгамдсан асуудал болоод байна.

### Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны давтан сургалт

Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчид зориулсан богино болон дунд хугацааны сургалтад 2020-2023 онд нийт 11815 төрийн захиргааны дэс түшмэлийн ангиллын албан хаагчид хамрагдсан байна.

Мэргэшүүлэх дунд хугацааны болон давтан, чиглүүлэх богино хугацааны сургалт



Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 2023 онд нийт 1923 албан хаагч хамрагдсан байна.

Тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн албан тушаалын мэргэшүүлэх багц болон богино болон дунд хугацааны сургалтад 2023 онд нийтдээ 3308 албан хаагч хамрагдсан байна.



Удирдлагын академиас “Шинэ сэргэлтийн бодлого”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг батлагдсантай холбогдуулан 2023 онд нийт 52,262 албан хаагчийн богино хугацааны сургалтад хамруулсан байна.

Төрийн албаны бүрэлдэхүүн хөдөлгөөний тоон мэдээлэлд төрийн захиргааны дэс түшмэлийн албан тушаалын ангилалд 17593 албан хаагч ажиллаж байна. Дэс түшмэлийн ангилалд ажиллаж буй албан хаагчийн албан тушаалын сургалт буюу мэргэшил хэсгийн “Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж төгссөн байх” тусгай шаардлагыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 90 дүгээр тогтоолд заасны дагуу Удирдлагын академиас байгууллагын захиалгаар болон тухайн чиглэлээр мэргэшүүлэх богино хугацааны зорилтот багц цагийн сургалтыг хамаарах зохицуулалт хийгдсэн нь үр дүнгээ өгч байна.

#### 5.4. Судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэл

Төрийн захиргааны албан хаагчийн шилжилт хөдөлгөөн, тогтвор суурьшлын өнөөгийн байдлыг Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо” цахим системийн сүүлийн 3 жилийн өгөгдөлд тулгуурлан дүн шинжилгээ хийж, тайлан<sup>5</sup> гаргалаа.

Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем дэх 2020-2022 оны шилжилт хөдөлгөөнд хамрагдсан 9037 албан хаагчийн бүртгэл мэдээллээс төрийн албан хаагчийн нас, хүйс, боловсрол, ажилласан жил, төрийн албаны ангилал, зэрэглэлийг гол үзүүлэлт болгон төрийн захиргааны албанаас халсан, чөлөөлсөн түр чөлөөлсөн, сэлгэн болон шилжин ажилласан албан хаагчийн хуулийн үндэслэл шалтгаан нөхцөл, төрийн албан хаагчийн туршлага, тогтвор суурьшлын өнөөгийн байдлыг харьцуулан судалж, гарсан үр дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлтийг боловсруулах зорилготой хийгдсэн тус судалгааны үр дүн нь дараах байдалтай байна.

<sup>5</sup> <https://drive.google.com/drive/folders/12DFAY4uLyAxAzc9GmTCc6myNwXSjINFi>

Төрийн захиргааны албаны нийт шилжилт хөдөлгөөний төрөл, оноор /2020-2022/



Тухайн судалгааг 2023 оны 1 дүгээр улиралд хийсэн бөгөөд 2020-2022 онд шилжилт хөдөлгөөн хамгийн их нь 2022 онд бүртгэгдсэн байна. Дээрх 5 шилжилт хөдөлгөөнөөс хамгийн их шилжилт хөдөлгөөний төрөл нь төрийн захиргааны албан тушаалаас чөлөөлөгдсөн 3681 төрийн захиргааны албан хаагч 40,7 хувийг эзэлж байна.

Төрийн албаны тухай хуулийн үндэслэлийг баримтлалгүйгээр шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг ХНУМТ цахим системд бусад хуулиар заасан үндэслэлийг баримтлан, хуулийн зүйл заалтыг буруу сонгон бүртгэсэн нь нийт шилжилт хөдөлгөөний 57,1 хувийг эзэлж байна.

Тодруулбал төрийн захиргааны албан хаагчийн шилжилт хөдөлгөөний хуулийн үндэслэлийг бүртгэсэн байдлыг судлан үзэхэд тухайн хөдөлмөрийн харилцааг зохицуулсан Төрийн захиргааны албан хаагч нь төрийн жинхэнэ албан хаагчид хамаарах бөгөөд төрийн захиргааны албан хаагчийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийхдээ Авлигын эсрэг, Агентлагийн тухай хууль, Боловсролын тухай Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол улсын Яамны эрх зүйн байдлын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Төсвийн хэмнэлтийн тухай, Засгийн газрын агентлагийн тухай, Татварын ерөнхий, Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн тухай, Прокурорын тухай, Шүүхийн тухай хуулийн холбогдох зүйл заалтуудыг сонгон бүртгэл хийсэн байна.

Төрийн захиргааны албан хаагчийн шилжилт хөдөлгөөн тус бүрийн хуулийн үндэслэлийг Төрийн албаны тухай хуулиар зохицуулж өгсөн. Тухайлбал төрийн захиргааны албан тушаалаас чөлөөлсөн, түр чөлөөлөх үндэслэлийг Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь хэсэгт, төрийн захиргааны албан тушаалаас халах үндэслэлийг 47 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.3, 48.4 дэх хэсэгт, төрийн захиргааны албан хаагчийг сэлгэн шилжүүлэн ажиллах үндэслэлийг 44 дүгээр зүйлд тус тус зааж өгсөн.


Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын тайланд гишүүн орнуудын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн 10-15 хувь<sup>6</sup> байхад хэвийн гэж үздэг бол судалгаагаар манай орны хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн нь 20.3 хувь буюу 2 дахин их үзүүлэлттэй гарсан нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэгт заасны дагуу төрийн алба мэргэшсэн тогтвортой байх зарчмыг хангахад бүх шатны төрийн байгууллага, түүний

<sup>6</sup> Brown, S., Garino, G., & Martin, C. (2009). Firm performance and labour turnover: Evidence from the 2004 workplace employee relations survey. *Economic Modelling*, 26(3), 689–695.

удирдлагууд анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна. Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн өндөр байгаа нь эдийн засгийн агуулгаар төрийн бүтээмжид сөргөөр нөлөөлдөг байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй Шинэ сэргэлтийн бодлогын “Төрийн бүтээмж”-ийн сэргэлтийн хүрээнд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 6440 төрийн албан хаагчдаас авах “Төрийн албаны чанарын цахим судалгаа”, “Төрийн албаны чанарын ярилцлагын судалгаа”-ны ажилд дэмжлэг үзүүлэн “Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв”-тэй хамтран ажиллалаа. Судалгаанд төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, төрийн улс төр, төрийн тусгай ангиллын нийт 29,165 албан хаагчид буюу Монгол Улсын нийт төрийн албан хаагчийн 12.9% нь оролцсон. Судалгаанд оролцсон албан хаагчийн хувьд 21 аймгаас 21611, нийслэлийн 9 дүүргээс 7554 албан хаагч тус тус оролцсон байна.


### “Төрийн албаны чанарын цахим судалгаа”



21 Аймгийн төрийн албан хаагчийн судалгаанд оролцсон байдал



9 дүүргийн төрийн албан хаагчийн судалгаанд оролцсон байдал



Судалгааны үр дүнгээр цалин хөлс, ажиллах орчин болон өсөн дэвших боломжтой холбоотой төрийн албанаас гарахад нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлж чадсан бөгөөд төрийн албаны удирдлага тухайн хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээ авч ажилласнаар чадвартай сайн албан хаагчдаа авч үлдэх боломж үүснэ гэж дүгнэж байна. Төрийн албанаас гарах сэдэлтэй албан хаагчид нь тодорхой хэмжээнд ажлын туршлага хуримтлуулсан, аливаад эрсдэл хүлээн төрийн албаны шинэчлэлд хувь нэмрээ оруулах хүсэлтэй залуу хүний нөөц байгаа нь ажиглагдлаа.

Цахим судалгааны үр дүнд төрийн албанд үлдэх сэдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсноороо шинэлэг юм. Энэ нь төрийн албаны менежмент, төрийн албан хаагчийн хандлага зан төлөвийг илүү сайн ойлгож, юуг нэмж сайжруулж болохыг төлөвлөх боломжтой юм. Төрийн албанд үлдэх сэдэлд “өсөн дэвших боломж” бусад хүчин зүйлстэй харьцуулахад өндөр нөлөөлж буй сонирхолтой үр дүн гарсан. Төрийн албанд ажилласнаар албан хаагчийн ур чадвар нэмэгдэж, ажил үүргээ гүйцэтгэх хангалттай чадамжтай болдог гэсэн үзүүлэлт өндөр байгааг харахад төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтууд эерэг үр нөлөөтэй нь харагдаж байна.

Нийтлэг байдлаар төрийн бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн албыг чанаржуулах гол шийдэл нь цалин хөлсийг нэмэгдүүлэх юм гэсэн ойлголт олон нийтэд байдаг боловч цалин хөлсний нэмэгдэл үндсэн шийдэл биш гэдгийг судалгааны үр дүн харуулсан.

## 5.5. Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн их өгөгдөл

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн зорилго нь төрийн албаны төлөв байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэдээллийг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх чиглэл, сургалтын хэрэгцээг оновчтой төлөвлөхөд оршино.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт[1] “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжүүлэх” зорилтыг дэвшүүлснээр төрийн байгууллагуудын мэдээллийн санг төрийн албанд ашиглах, интеграци хийж нэгтгэх шийдлийг тодорхойлон “Төрийн их өгөгдөл”-ийг бий болгохоор ажиллаж байна.

Төрийн байгууллага, албан хаагчийн тоо бүртгэлийг Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйл болон Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журмын дагуу Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системээр хөтлөн явуулж байна.


Төрийн их өгөгдлийн нэг хэсэг болох төрийн байгууллага, албан хаагчийн бүртгэлийн мэдээллийн санг бий болгох, төрийн албаны шинэтгэлийг дэмжсэн бодлого, хууль эрх зүйн хүрээнд нийцсэн, хэрэглэхэд хялбар, хүртээмжтэй, сүүлийн үеийн технологид суурилсан, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийг хөгжүүлэх урт хугацааны бодлогын баримт бичгийг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 5 сарын 29-ны өдрийн 193 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем



Төрийн албаны тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу бусад төрийн байгууллагын мэдээллийн сангаас төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан мэдээлэл авч мэдээллийн үнэн зөв байдлыг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд 2023 онд боловсролын мэдээллийн сангаас суурь, бакалавр, магистр, докторын бүртгэлийн мэдээлэл, иргэний бүртгэлийн мэдээллийн сангаас иргэний үнэмлэхийн мэдээлэл, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт болон гадаад иргэний бүртгэлийн мэдээллийг анхдагч эх үүсгэврээс тус тус авч байна.

ХНУМТ системтэй мэдээлэл солилцоо хийж байгаа системүүд:



Төрийн албаны тоо бүртгэлийн мэдээллийн сангаас албан хаагчийн мэдээллийг “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”-д нийлүүлж байгаа нь ижил төрлийн мэдээллийг

нэг эх үүсвэрээс ашиглах, төрийн албан хаагчийн орон тооны нарийвчилсан мэдээ гаргах, төлөвлөлт хийх боломж бүрдлээ.

Мэдээллийн систем хооронд өгөгдөл солилцох интеграцийг хөгжүүлснээр цахим орчинд байгаа бүрэн, үнэн зөв мэдээллийг иргэн, төрийн албан хаагчаас дахин шаардахгүй болж цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлт бий болохоос гадна Төрийн алба, төрийн албан хаагчидтай холбоотой үнэн зөв, давхардал, зөрүүгүй статистик тоон мэдээлэлд суурилсан бодлого, шийдвэр гаргахад ашиглах их өгөгдөл бүрдэж, төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглаж буй мэдээллийн системүүдэд байгууллагын бүтэц, албан хаагчийн мэдээллээр хангах анхдагч эх үүсгэвэр болох нөхцөл бүрдэж байна.



“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд бүртгэлтэй төрийн 4239 байгууллагын 226496 албан хаагч бүртгэлтэй байгаа бөгөөд уг бүртгэлийг хариуцан ажиллаж буй төрийн байгууллагуудын албан хаагчдад мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт оруулах чиглэлээр 52 цагийн сургалт, зөвлөгөөг цахимаар зохион байгуулж, давхардсан тоогоор 18658 албан хаагчийг хамруулсан.

ХНУМТ цахим системд цалин, хөлсний бүтэц болох үндсэн цалингийн 71 сүлжээ, 377 төрлийн нэмэгдэл цалин хөлсний бүртгэлийг оруулснаар төрийн албан хаагчийн цалин хөлсний талаарх мэдээллийг бодитой, үнэн зөв бүртгэж, нэмэгдэл цалин хөлсийг давхардуулан олгох, илүү олгох, дутуу олгох, зөрүүтэй олгох, буруу олгох зэрэг зөрчлийг арилгахад чухал шийдэл болсноос гадна цалин хөлсний бодлогыг тодорхойлоход ач холбогдолтой тоон мэдээллийг цуглуулжээ. Энэ нь цалин хөлсний талаар төрийн албаны хэмжээнд баримтлах бодлогыг тодорхойлох, боловсронгуй болгох, цалин хөлсний талаарх бодлогыг шинэчлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээний ажлын бодитой эх сурвалж болох юм.

Цаашид өгөгдлийг анхдагч эх үүсгэврээс цуглуулж түүний чанар сайжирч төрийн албан хаагч мэдээллээ өөрөө хянах, удирдах, төрийн албан хаагчийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Төрийн албатай холбоотой судалгааны ажлын чиглэлийг оновчтой тогтоож, судалгааны арга зүйг боловсронгуй болгож, төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн тоо бүртгэл, мэдээлэлд тулгуурлаж, мэргэшлийн эрдэм шинжилгээ судалгааны хүрээлэнгүүдтэй хамтран ажиллаж, судалгааны үр дүнг төрийн албаны шинэтгэлийн бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын төрийн албаны үр ашгийг олон улсын төрийн албаны үр ашгийн түвшинд хүргэх зорилгоор олон улсын туршлага судлан, харьцуулсан судалгаатай болж, төрийн албаны тухай хууль, тогтоомжид тусгаж, бодитой хэрэгжүүлснээр олон улсын төрийн албаны үр ашгийн индексийн үзүүлэлтүүдийг өөрийн оронд нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, дутагдаж байгаа мэдлэг чадварыг тодорхойлж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж, сургалтын хийх шаардлагатай байна. Цаашлаад төрийн албан хаагчийн ажлын чадамжийг дээшлүүлж, тогтвор суурьшилтай ажиллах урьтал нөхцөлийг бүрдүүлэхэд ажил, мэргэжлийн болон бусад хэрэгцээний ур чадварын хэмжүүр үзүүлэлтийг



тодорхойлоход судалгаа, шинжилгээний ажлыг чиглүүлснээр төрийн албаны сургалтын хүрээ өргөжнө.

Төрийн албаны сургалтын тогтолцоог өргөжүүлж, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хийж, цахим сургалтын хэрэгцээ, шаардлагыг судлахын зэрэгцээ олон улсын төрийн албаны сургалтын арга зүй, сургалтын тогтолцоог нэвтрүүлэхээр судалж байна.

## 5.6. Төрийн албаны хүний нөөцийн бүрдүүлэлт

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8, 42 дугаар зүйлийн 42.1.6, 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлээр Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлд заасан жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй байгаа төрийн жинхэнэ албан хаагчийн эзгүй байх хугацаанд холбогдох хууль, журмын дагуу төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа иргэнийг томилон ажиллуулсан тохиолдолд тухайн иргэний төрийн жинхэнэ албаны нөөцөд байх хугацааг тооцох болон Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийн “Төрийн жинхэнэ албанд анх орсон иргэнд туршилтын хугацааг 6-12 сар хүртэл хугацаагаар тооцож болно” гэсэн хуулийн хэрэгжилтийг хангах агуулга бүхий зөвлөмжийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлүүдээр дамжуулан, төрийн байгууллагуудад хүргүүлж мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан.

Төрийн албаны тухай хуульд 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр төрийн улс төр, төрийн тусгай, төрийн үйлчилгээний ангиллаас төрийн захиргааны ангилалд ур чадварын шилжилт хийх эрх зүйн шинэ орчин бүрдсэн. Энэ төрийн албаны хүний нөөцийн удирдлагын бодлогын шинэтгэлийн хүрээнд төрийн албаны өөр өөр ангиллын албан тушаалуудыг адилтгах, ажилласан хугацааг дүйцүүлэн тооцох болсноор ажилтны туршлага, ур чадварыг ашиглах замаар сэлгэх, шилжүүлэх, хүний нөөцийн нөхөн хангалтыг тэлэх боломж нээгдэж, төрийн албанд тулгарч буй хүний нөөцийн хомсдолыг тодорхой хэмжээгээр нөхөх нөхцөлийг бүрдүүллээ.

## 5.7. Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгох

Тайлант онд Улсын Их Хурлын харьяа 5 байгууллага, 7 яам, 13 агентлаг, нутгийн захиргааны 24 байгууллага, бусад 3 байгууллага, нийт 52 байгууллагын удирдах албан тушаалын 285, гүйцэтгэх албан тушаалын 1323, нийт 1608 албан тушаалын тодорхойлолтод батлах зөвшөөрөл олгосон. Үүнээс шинээр 554, шинэчлэн 972, өөрчлөлт оруулсан 82, хүчингүй болгосон 996 байна.

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, хянах, батлах зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулах “Албан тушаалын тодорхойлолт” системийг “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн дэд систем байдлаар хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлээд байна.

Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо” цахим системд бүртгэж, системээр хянаж,

зөвшөөрөл олгохтой холбоотойгоор салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нарыг чадавхжуулах зорилгоор 3 удаагийн сургалт зохион байгуулж, чиглэл зөвлөмж өгч ажилласан. Нийт 22 төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалын тодорхойлолтод санал хүргүүлж ажилласан байна.

Он	Батлах зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт								Хүчин төгөлдөр байгаа АТТ-ын тоо
	АТТ-д хамаарах төрийн захиргааны албан хаагчийн тоо	Батлах зөвшөөрөл олгосон нийт АТТ-ын тоо	Үүнээс			Хүчингүй болгосон АТТ-ын тоо	Үүнээс		
			Шинээр баталсан	Шинэчлэн баталсан	Өөрчлөлт оруулсан		Бүтэц, чиг үүргийн өөрчлөлтөөр хүчингүй болгосон	Шинэчлэн батлах өөрчлөлтөөр хүчингүй болсон	
2019	19008	14036	14036						
2020	20553	7308	6709	580	19				
2021	21135	990	560	308	122	513	282	231	
2022	22023	2155	1077	861	217	1938	1077	861	
2023	27304	1608	554	972	82	996	173	823	
<b>Нийт</b>		<b>26097</b>	<b>22936</b>	<b>2721</b>	<b>440</b>	<b>3447</b>	<b>1532</b>	<b>1915</b>	<b>22750</b>

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолын 1-5 дугаар хавсралтын “Мэргэшил” хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 267 дугаар тогтоолоор “... сургалтад хамрагдаж, төгссөн байх” гэж нэмэлт, өөрчлөлт оруулж хууль, журмын нийцлийг хангуулсан нь тухайн багц сургалтад хамрагдаж байгаа болон багц сургалтыг төгссөн иргэн, албан хаагч сонгон шалгаруулалтад адил тэгш эрхтэйгээр оролцох боломжийг хангаж чадсан зохицуулалт боллоо.

Төрийн албаны зөвлөлөөс албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгох тогтолцоо нь иргэн, албан хаагчид зориулж албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж батлах, өөрчлөх боломжийг хязгаарласан, хуульд заасан шаардлага хангасан иргэнийг зохих журмын дагуу сонгон шалгаруулах, төрийн албанд шатлан дэвшүүлэх боломжийг бүрдүүлэх, төрийн алба мэргэшсэн тогтвортой байх томоохон суурь шинэчлэл болсон.

“Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.2, 18.3.4 дэх заалт, Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж гаргасан зөвлөмж, Жендерийн үндэсний хорооны 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031 он)”-ний 3.4.3 дахь заалт, Хорооны 2023 оны ээлжит хуралдааны “Хэрэгжилтийг зохион байгуулах” тухай 5 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Жендерийн үндэсний хороотой хамтран



ажиллаж, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 341 дүгээр тогтоолоор Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого /хөгжил/-ын хэлтсийн Жендерийн эрх тэгш байдал, салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн"-ий албан тушаалын тодорхойлолтыг шинээр баталсан.

2023 оны 11 сард НҮБХХ-ийн төслийн багтай уулзалт хийж “Төрийн байгууллагуудад хэрэгжүүлэх Жендерийн тэгш байдлын гэрчилгээжүүлэлт” сэдвээр санал солилцож, хэрэгжүүлж буй ажлын талаар мэдээлэл солилцсон.

### **5.8. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг чадавхжуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх**

Тайлант онд 11 яам, 8 агентлаг, 11 аймаг, нийслэлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг Зөвлөлийн хурлаар хэлэлцэн 45 тогтоолыг баталсан.

Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын сургалтын хэрэгцээг тодорхойлох, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тэдний хүний нөөцийн мэдээлэл, томилгоо, мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байдал, хамрагдахыг хүсэж буй сургалтын санал, хамрагдах хэлбэр, төлбөрийн нөхцөл, мөн салбар зөвлөлд тулгамдаж буй асуудал, дээд байгууллагад уламжлах асуудал бүхий 13 асуулгаар судалгааг цахимаар авч, боловсруулалт хийлээ. Судалгаанд суурилсан тодорхой арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна.


Нийслэл, 21 аймаг, яам, агентлагийн Салбар зөвлөлийн нийт 43 нарийн бичгийн дарга нарыг хамруулан төрийн албаны хүний нөөцийн аудитын гэрчилгээ олгох мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулснаар тухай орон нутаг, төрийн байгууллагадаа хүний нөөцийн аудит зохион байгуулах, аудитын багт ажиллах, Төрийн албаны төв байгууллагаас томилсон хүний нөөцийн аудитын багт төлөөллөөр, гишүүнээр ажиллах нөхцөл бүрдсэн.

## ЗУРГАА. ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 6.1. Бүтэц, зохион байгуулалт бусад үйл ажиллагаа

Зөвлөл нь хараат бус, бие даасан байгууллага бөгөөд ажлын алба, салбар зөвлөл, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг хууль тогтоомж<sup>7</sup>-д заасны дагуу тогтоон мөрдүүлж ирлээ.

#### Төрийн албаны зөвлөлийн бүтцийн бүдүүвч



Төрийн албаны зөвлөлийн ажлын алба 56 орон тоотой, 2023 оны батлагдсан төсөв 3856.4 сая төгрөг, гүйцэтгэл 3469,9 сая төгрөг байна.

2023 онд төрийн албаны шинэтгэлийн бодлого, үйл явц, талуудын оролцоо, хамтын ажиллагаа, шинэ санаа, инновац, төрийн албан хаагчийн харилцаа хандлага, зан үйлд нөлөөлөх болон сургаж чадавхжуулах, сорил, бэрхшээл, үр дүнгийн талаар мэдээллээр байгууллага, албан тушаалтан, иргэд, олон нийтийг хангаж, соён гэгээрүүлэх контентуудыг бэлтгэн, тухай бүр [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn), [www.facebook.com/TAZuvlul](https://www.facebook.com/TAZuvlul) хуудсаар олон нийтэд түгээж, Зөвлөлийн үйл ажиллагааны талаар нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллав.

Байгууллагын албан ёсны цахим хуудас [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) хаягаар дамжуулан Төрийн албаны зөвлөлийн бодлого, үйл ажиллагааны 200 гаруй удаагийн мэдээ, мэдээллийг бэлтгэн, 1000 гаруй гэрэл зургийн хамт нийтэлж, 1 сая 200 гаруй нийгмийн сүлжээний хэрэглэгчийн хандалттайгаар мэдээ, мэдээлэл авсан байна.

<sup>7</sup> Монгол Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”

Төрийн албаны зөвлөлийн бодлого чиглэлийг сурталчлан таниулах, мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд шуурхай хүргэх зорилгоор Facebook page хуудсанд дагагч 12 хувиар нэмэгдэж, нийтэлсэн мэдээ, мэдээллээр 118 мянган хандалт авсан байна. Мөн 15775 гишүүнтэй ТАЗ-HR группийг хөтлөн мэдээлэл өгч ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг нэг цонхоор мэдээлэх, төрийн албатай холбоотой хийж гүйцэтгэсэн судалгааны материал, 7:4:10 зэрэг сургалтын бичлэг, мэдлэгийн сан, гарын авлага, номыг нийтийн хүртээл болгох боломж бүрдсэн цахим платформыг хөгжүүлээд байна.

Тайлант хугацаанд Баян-Өлгий, Баянхонгор, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Ховд, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Хэнтий аймаг, Нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай дүүрэгт Төрийн албаны тухай хууль, төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, зөвлөн туслах, сургалт арга зүйн зөвлөгөө өгөх, Ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах чиглэлээр орон нутагт ажиллалаа.


## 6.2. Төрийн албаны зөвлөлийн хуралдаан

Зөвлөл 2023 онд нийт 48 удаа хуралдаж төрийн албаны шинэтгэл, хууль дээдэлсэн сайн засаглалыг бэхжүүлэх, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын 430 гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 585 тогтоол гаргасан байна.

Төрийн албаны зөвлөлийн хуралдааны тойм

Д/д	Он	Хуралдааны тоо	Хэлэлцсэн асуудлын тоо	Хуралдсан цаг, минут
1	2019	47	372	203 цаг
2	2020	66	328	145 цаг
3	2021	55	336	171 цаг
4	2022	54	389	239 цаг
5	2023	48	585	430 цаг

Төрийн албаны зөвлөлийн хуралдааны талаар тоон мэдээллийн график



Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар дүрэм, журам, зөвлөмжийн төсөл 6, албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл олгох эсэх 89, ерөнхий болон тусгай шалгалттай холбоотой асуудал 109, төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвтэй холбоотой асуудал 7, маргаан хянан шалгах комиссын дүгнэлт 52, салбар зөвлөлтэй холбоотой асуудал 68, зөвлөн туслах, хяналт шалгалт хийх ажлын тайлан 11, шагналтай холбоотой асуудал 10, бусад асуудал 22 хэлэлцсэн байна.

2023 оны Хуралдаанд оруулсан асуудал  
/нийт- 430/



2023 онд Төрийн албаны зөвлөлд 3417 албан бичиг ирсэн бөгөөд энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 7 хувиар буурсан, 1196 өргөдөл, гомдол ирсэн нь өмнөх оноос 9 хувиар өссөн байна. Төрийн албаны зөвлөлөөс 2607 албан бичгийг холбогдох иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллагад явуулсан бөгөөд өмнөх оноос 7 хувиар өссөн байна. Иргэд байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэн холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдэд хариу хүргүүлж ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлөөс 2019-2023 онд шийдвэрлэсэн  
албан бичиг, тогтоол, шийдвэрийн тоон мэдээлэл



### 6.3. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төсөл


Монгол Улсад хэрэгжүүлж буй төрийн албаны шинэтгэлийг төрийн албаны төлөвшил, хөгжлөөр олон улсад тэргүүлэгч орнуудын Засгийн газар, олон улсын байгууллагууд талархан дэмжиж ирсний нэг нь Канад Улс бөгөөд Канад Улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг 2018-2023 онд Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран амжилттай хэрэгжүүллээ.

Төсөл нь төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлж Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шаардлагатай дүрэм, журам, аргачлалыг чадахуйн зарчимд суурилан боловсруулах, төрийн байгууллага, албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх, мэргэшлийн хөгжлийг дэмжих үндсэн зорилготой бөгөөд төслийн зорилгод хүрэхийн тулд харилцан уялдаа бүхий дараах дөрвөн зорилтыг дэвшүүлэн ажилласан. Мэргэжлийн төрийн албыг төлөвшүүлэхэд чиглэсэн эрх зүй, бодлогын хүрээ сайжруулах; Төрийн албан хаагчийн мэргэжлийн чадавх сайжруулах; Төрийн захиргаан дахь Жендерийн тэгш байдал дээшлүүлэх; Төрийн захиргааны ажлын гүйцэтгэлд иргэн төвтэй хяналт бий болгох зорилтыг хэрэгжүүлэн ажилласан.


Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд чадахуйн зарчмыг төрийн албанд төлөвшүүлэх, бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, аргачлал, хэрэглэгдэхүүнийг боловсруулахад иж бүрэн дэмжлэг үзүүлсэн. Үүний үр дүнд төрийн жинхэнэ албан хаагчид тавих ерөнхий шаардлага, албан тушаалын тодорхойлолт, төрийн албаны сонгон шалгаруулалт, томилгоо, хүний нөөцийн удирдлага, ажлын гүйцэтгэл, сахилга хариуцлага, ёс зүйн зэрэг хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг зохицуулсан 12 дүрэм, журмыг чадахуйн зарчимд нийцүүлэн боловсруулж, батлуулсан.

“Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл үр дүнгээ тооцож, хэрэгжих хугацаа 2023 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс дууссан бөгөөд төслийн хэрэгжих хугацаанд төслийн санхүүгийн эзлэх хувь хэмжээг авч үзвэл:

2018	2019	2020	2021	2022	2023
\$916,042.12	\$1,253,931.65	\$897,621.43	\$1,103,832.62	\$1,015,087	\$255,809



Төслийн санхүүжилтэд эзлэх хувь



## ДОЛОО. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮГНЭЛТ

1. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, шинэтгэлийн эхний үеийн /2019-2023/ үр дүнгийн сургамж, дүгнэлтийг нэгтгэн, зорилго зорилтоо тодорхойлон, төрийн албаны мерит тогтолцооны үндэс суурийг бэхжүүлснийг Монгол Улсын Их Хурлаас дүгнэв.

Төрийн албаны зөвлөл 2023 онд УИХ-ын нэгдсэн чуулганд үйл ажиллагааны тайланг анх удаа хэлэлцүүлснээр төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, цалин хөлсний тогтолцоог бүтээмж, ажлын үр дүнтэй уялдуулан, шинэ сэргэлтийг дэмжих бодлогын хувилбарыг хэрэгжүүлэх тогтоол шийдвэрийг төрийн албаны судалгаанд үндэслэсэн нь томоохон ахиц гарав.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл холбогдох төрийн захиргааны төв байгууллага хамтран төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах, тодорхой салбар, төрийн үйлчилгээнд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж ажилласны үр дүнд 2023 онд төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангах зорилгод томоохон ахиц гарсан гэж дүгнэж байна.

2. Шалгалтын бүрэлдэхүүн, агуулгыг олон улсын жишигт нийцүүлж, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган, сонгон шалгаруулалтын журмуудыг нэгтгэн шинэчилж, үр дүнг цахим системд нээлттэй болгов. Салбарын онцлогийг харгалзан захиалгат ерөнхий шалгалт зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн жинхэнэ албанд орж ажиллах, шатлан дэвших боломж нэмэгдлээ.

3. Төрийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр улс төрийн албан тушаалыг дүйцүүлэх, төрийн тусгай болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны зохих албан тушаалтай адилтгах дүрэм, журмыг боловсруулан батлуулж хэрэгжүүлснээр төрийн албаны албан тушаалын ангилалд ур чадварын шилжилт хийх, ангилал хооронд нөөцийн бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалт шинэчлэгдлээ.

4. Төрийн албаны зөвлөлийн вебинар 7:4:10 сургалтын хамрах хүрээ өргөжиж, цахим сургалтын жишиг соёлыг түгээн, албан хаагчдыг ангилал зэрэглэл харгалзахгүйгээр мэдлэг, мэдээлэл олгож хэвшсэнээр, 2023 онд 240 мянга гаруй төрийн албан хаагч хамрагдлаа.

5. Төрийн албаны мэргэшүүлэх сургалтын шаардлагыг шинэчлэн, төрийн албан тушаал бүрээр мэргэшүүлэх сургалтын тогтолцоо бүрдүүлсэн бөгөөд агуулгыг өргөжүүлж, зайнаас суралцах, үнэлж дүгнэх, цахим платформ нэвтрүүлэн суралцах боломжийг нэмэгдүүлэн, чадахуйн болон төрийн алба хаах адил тэгш боломжийг хангах зорилгоор албан тушаалын тодорхойлолтын нийтлэг стандартыг мөрдүүлэн зөвшөөрөл олгон хэрэгжүүлж байна.

Төрийн албаны зөвлөлөөс албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгох тогтолцоо нь иргэн, албан хаагчид зориулж албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж батлах, өөрчлөх боломжийг хязгаарласан, хуульд заасан шаардлага хангасан иргэнийг зохих журмын дагуу сонгон шалгаруулах, төрийн албанд шатлан дэвшүүлэх боломжийг бүрдүүлэх, төрийн алба мэргэшсэн тогтвортой байх томоохон суурь шинэчлэл болсон.

6. “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн хөгжүүлэлтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэн, өгөгдөл мэдээллийг чанаржуулж, мэдээлэл солилцоог өргөжүүлж, ЗГХЭГ-ын мэдээллийн системтэй холбон судалгаанд суурилсан судалгаа тооцоолол хийх боломж бүрдүүлэв.



7. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинээр батлагдаж, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг тогтоосон эрх зүйн зохицуулалт, тогтолцоог бүрдүүлэх эхлэлийг бүрдүүлж, соён гэгээрүүлэх сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулав.

8.Төрийн албан дахь хүний нөөцийн шийдвэр, томилгоо, цахим системийн мэдээллийн бүрдлийн хяналт шалгалтад 267 төрийн байгууллагын 4884 албан хаагч буюу 21 аймаг, нийслэлийг хяналт шалгалтад бүрэн хамруулж, илэрсэн зөрчлийг арилгуулан, хууль бус зөрчилтэй томилгоо огцом буурчээ.

Хяналт шалгалтын хүрээнд төрийн захиргааны албан хаагчийн 56.3 хувийг хяналт, шалгалтад хамруулсан бөгөөд 2022 онд төрийн захиргааны албан тушаалд томилогдсон нийт албан тушаалтны 19 хувь нь зөрчилтэй томилгоотой байсан бол 2023 онд 9.6 хувь болж буурсан үзүүлэлт гарсан нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажилд бодит үр дүн гарч байгаагийн илрэл гэж дүгнэж байна.

9. Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх 156 нэхэмжлэл гаргаж, 443.3 сая төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхээр шийдвэрлүүлж, 253.6 сая төгрөгийн хохирлыг барагдуулсан нь хариуцлага, эдийн засгийн хөшүүрэгтэй болсны үр дүнд хуулийн хэрэгжилт сайжирч байна.

Эрх бүхий албан тушаалтны зүгээс төрийн албаны хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилох тохиолдол буурч, үр дүнд хүрч байгаа нь Төрийн албаны зөвлөлөөс өнгөрсөн хугацаанд эрчимтэй зохион байгуулсан хяналт шалгалтын үйл ажиллагаа болон хууль зөрчсөний улмаас төрд учруулсан хохирлыг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх ажлыг эрчимжүүлсэнтэй холбоотой юм.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “АЛСЫН ХАРАА-2050”-д тусгасан иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлэх зорилтыг хангах, Төрийн албаны тухай хуулийн суурь зарчим болох Чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн албаны зөвлөл төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах, хугацаатай үүрэг даалгавар хүргүүлж, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох чиг үүргийг хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрч байна.

## НАЙМ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ САНАЛ

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төрийн албаны шинэтгэлийн зорилтуудтай уялдуулан Төрийн албаны хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг жил бүр Монгол Улсын Их Хурал, Байнгын хороонд хүргүүлэн хамтран ажиллаж хэвшсэн болно.

Цаашид улс орны хөгжлийн бодлого, шинэтгэлийн үйл явц, хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан Төрийн албаны хууль тогтоомжийг боловсронгуй болгох хуулийн үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн дараах саналыг уламжилж байна.

### НЭГ. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТҮВШИНД

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигийн хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг шинэчлэн батлах**

Төрийн албаны тухай хууль 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам” шинэчлэгдээгүй. Төрийн захиргааны албан хаагч нь тангараг өргөсний дараа төрийн албанаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, төрийн албаны ерөнхий шалгалт болон тусгай шалгалтыг өгч дахин төрийн захиргааны албанд томилогдоход тангараг өргөх эсэх, тангараг өргүүлэх хугацааг тодорхой тусгагдаагүй, тангаргийг албан хаагчийн хувийн хэрэгт хадгалдаг, албан хаагч тангаргаа дээдлэн, мөрдөж байгаа нь зарим тохиолдолд нотлогдохгүй зэргээс төрийн захиргааны байгууллага тангаргийн журмыг өөр өөрөөр ойлгож хэрэгжүүлэх, цаг үеийн болон нийгмийн шаардлагаар журмыг зайлшгүй шинэчлэн батлах шаардлагатай болсон.

### ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТҮВШИНД

Сайн засаглалын үзэл баримтлал, чадахуйн зарчим /мерит/-д тулгуурласан, мэргэшсэн, тогтвортой ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “... хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэж заасан. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Төрийн албаны тухай хууль болон дагалдан гарсан дүрэм, журмын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, шинэчлэх ажлыг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Энэ нь хуулийн зорилт хангагдаж байгаа эсэх, хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх, төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлагын зохион байгуулалт, хөдөлмөрийн харилцааны зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэгдсэн, хуулийг зөв ойлгож хэрэгжүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ач холбогдолтой юм.

Төрийн албаны тухай хууль 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд нийт 23 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байхаар хуульчилсан ч төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг нарийвчлан зохицуулсан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төрийн албаны төв байгууллагын саналыг зохих журмын дагуу авахгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд эрсдэл үүсэхээр байна.

Тухайлбал, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.” гэж заасан нь хууль хоорондын зөрчил үүсгэж байна.

Төрийн албаны тухай хууль тогтоомжид дараах зохицуулалтыг тусгаж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналтай байна.

## **2.1.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах**

2.1.1.Төрийн албанаас хууль бусаар халагдсан, чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөнийг шүүх болон төрийн албаны төв байгууллага тогтоосон боловч томилох эрх бүхий албан тушаалтан албан хаагчийг ажилд нь эгүүлэн томилохгүй эс үйлдэхүй гаргах, шүүхийн шатанд талууд эвлэрэх, гомдол нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх зэргээс шалтгаалж, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэж байгааг хуулийн зохицуулалтад нарийвчлан тусгаж, эдийн засгийн хариуцлагыг тодорхой болгож хуульчлах.

2.1.2.Төрийн захиргааны албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг бууруулсан нь төрийн захиргааны зохих шатанд ажилласан мэргэшсэн төрийн албан хаагч шатлан дэвших зарчмаар томилогддог байх үзэл баримтлалтай зөрчилдөж байгаа бөгөөд хуульд тус нэмэлт, өөрчлөлтийг оруулахдаа нарийвчилсан судалгаанд үндэслэх, олон нийт, судлаачдаар хэлэлцүүлэх зайлшгүй шаардлагатай байсан. Цаашид хууль тогтоомжийн аливаа нэмэлт, өөрчлөлтийг төрийн албаны шинэтгэлийн зорилт, мэргэшсэн, тогтвортой, шатлан дэвших, чадахуйн зарчмын үзэл санаанд нийцүүлэх.

2.1.3.Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулахтай холбоотой харилцаа нь төрийн албаны хүний нөөцийн удирдлагын томилгооны шийдвэрийн нэг хэлбэр тул Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт 44 дүгээр зүйлийг нэмж тусгах.

Учир нь хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах томилгоотой холбоотой төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааг хангах хуулийн зохицуулалтыг хийх шаардлагатай байна.

2.1.4.Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн “66.1.4.төрийн албаны тухай хууль тогтоомж, энэ хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчмын хэрэгжилтийн талаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх;” гэсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд зарим дүрэм, журмын зохицуулалт дутагдалтай байна.

Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн “59.1.Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагах мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.” гэж заасны дагуу Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлд “Энэ хуулийн 66.1.4-т заасан төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх журмыг Улсын Их Хурал тогтооно.” гэж нэмэлт, өөрчлөлт оруулах.

2.1.5.Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтын захиалгыг хуульд заасан хугацаанд Зөвлөл, салбар

зөвлөлд хүргүүлээгүйгээс хууль бус томилгоо хийгдэх, албан хаагчдад ажлын ачаалал нэмэгдэх сөрөг үр дагаврууд практикт түгээмэл байна.

Иймд Зөвлөл, салбар зөвлөл өөрийн санаачилгаар сул орон тоо нөхөх сонгон шалгаруулалтыг зарлах зохицуулалтыг хуульчлах.

## **2.2.Улсын Их Хурлын 2019 оны 20 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-д өөрчлөлт оруулах**

Төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шалгах ажиллагаа болон түүнийг шийдвэрлэх явцад зарим тодорхойгүй, зохицуулалтгүй асуудал үүссэн, журмын зохицуулалт хооронд зөрчил, хийдэл гарч байгаа тул дараах нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй байна.

2.2.1.Маргаан хянан шалгах комисс маргааны нөхцөл байдлыг тодруулж, нотлох үүрэгтэй байх зарчим, гомдол гаргагч нь гомдолдоо үндэслэл, гомдлын шаардлагаа тодорхой бичээгүйгээс Зөвлөлөөс гарах шийдвэрийн төрөлд нөлөөлдөг тул гомдлын агуулга ба шаардлагыг тодорхой тусгадаг байх;

2.2.2.Талуудын маргаж буй үйл баримтад шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техник, технологийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулж, маргааныг хянан шалгаж, шийдвэрлэх нөхцөл байдал үүсдэг тул шинжээчийг маргаан хянан шалгах ажиллагаанд оруулж, дүгнэлт гаргуулснаар маргаж буй асуудал үнэн зөв, эргэлзээгүй шийдвэрлэх боломжтой нөхцөл бүрдэх, шинжээч томилсон болон эрүү, иргэн, захиргааны журмаар шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө уг маргааныг хянан шийдвэрлэх боломжгүй тохиолдолд маргаан хянан шалгах ажиллагааг түдгэлзүүлснээр хуульд заасан хугацаа алдахгүй, процессын зөрчил гаргахгүй байх, түдгэлзүүлэх шалтгаан арилсан тохиолдолд маргаан хянан шалгах ажиллагааг сэргээх зохицуулалтыг бий болгох;

2.2.3.Маргагч талууд эвлэрч, харилцан ойлголцсон тохиолдолд гомдлоосоо татгалзах, захиргаа шийдвэрээ хүчингүй болгох, өөрчлөх зэрэг уян хатан зохицуулалтыг оруулж өгснөөр маргааныг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх;

2.2.4.Маргаан хянан шалгах журам зөрчсөн, уг ажиллагаатай холбоотой хуурамч бичиг баримт бүрдүүлэх, тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргасан тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх заалтыг тус тус журамд шинээр тусгах;

2.2.5. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд зааснаар Улсын Дээд шүүхийн бүрэн эрхийн хүрээнд Төрийн албаны тухай хуулийн зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх зорилгоор хуулийн тайлбар гаргуулах;

2.2.6. Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газартай мэдээлэл солилцох цахим системийг бий болгох зохицуулалтыг тусгах.

## **2.3.Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах**

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацааг өөрчилж, хуульд

нийцүүлэх, албан тушаалын ангилалд үндэслэн төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв олгох эрх бүхий албан тушаалтныг журамд тодорхой тусгах.

“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацааг өөрчлөөгүйгээс төрийн байгууллагууд Төрийн албан тухай хууль, журмыг өөр өөрөөр хэрэглэж байна.

#### **2.4.Төрийн албаны төв байгууллагын бүтэц, зохион байгуулалтын нэгжийг Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын бодлогын зорилттой уялдуулан шинэчлэн тогтоох, шаардлагатай төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх**

Улсын Их Хурлын 2019 оны “Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны бүтэц батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” 07 дугаар тогтоолоор Ажлын албаны бүтцийг 4 газар, орон тооны дээд хязгаарыг 56 албан хаагчтай байхаар, Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийг байгуулж ажиллуулахыг Төрийн албаны зөвлөлд зөвшөөрч, энэхүү нэгжийн орон тоо, цалингийн зардлыг шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийн орон тоо, үйл ажиллагааны зардал шийдвэрлэгдээгүйгээс өнөөдрийг хүртэл Ажлын албаны бүтцэд багтаан ажиллуулж байна.

Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын бүтэц, орон тоог Ажлын албаны орон тооноос тусад нь баталж, чиг үүргийг нь тусгайлан хэрэгжүүлэх шаардлага тулгамдаж байна.

Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх зорилгоор Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоог шинэчлэн тогтоох нь зүйтэй байна.

Иймд Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоож, Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрыг бүтэц, орон тооны дагуу ажиллуулахад шаардлагатай төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх шаардлага үүссэн.

Түүнчлэн олон улсын жишигт нийцүүлж, хувь хүний мэдлэг, ур чадвар, зан үйлд суурилсан “Ур чадварын хүрээ”-г тодорхойлох, төрийн албаны шалгалтын сорил, даалгавар, ярилцлагын санг боловсруулах бие даасан “Ур чадварын үнэлгээний төв”-тэй болох шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна.

#### **2.5. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны эрх зүйн үндсийг тогтоох, мөн цалин хөлс, нийгмийн баталгааг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг нэгдсэн зохицуулалтад оруулж, шинээр хуульчлах**

Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг тухайн салбарын хууль тогтоомжоор зохицуулж ирсэнтэй холбоотой адил албан тушаалд харьцангуй өндөр цалин хөлс тогтоох, төрийн албан хаагчид олгож буй тэтгэмж, нөхөх олговор, төлбөр тусламжийн хэмжээг тухайн салбарын хууль тогтоомжоор ялгаатай байдлаар зохицуулж байна.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан цалин хөлсний нэгдмэл бодлого, адил албан тушаалд ижил цалин хөлс олгох зарчим алдагдаж, салбар хоорондын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, төрийн албанд тогтвор суурьшилгүй байдал үүсэж байгаа тул төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг тусгайлан хуульчлах шаардлагатай болсон.

### **3.1.Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах**

“Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-д төрийн албан хаагчийн бүртгэх мэдээллийг багасгах, өгөгдлийн сан, албан хаагчийн мэдээллийг холбогдох төрийн байгууллагын мэдээллийн системээр дамжуулан ашиглах боломжийг бүрдүүлэх, тоо бүртгэл хөтлөх байгууллага, албан тушаалтны үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, албан хаагчийн оролцоог хангах, мэдээллийн системийн чанар, өгөгдлийн үнэн зөв байдлыг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох албан хаагчид цалин хөлсний нэмэгдэл олгох зохицуулалтыг тусгах.

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд төрийн албан тушаалд тавих шаардлага хангасан иргэнийг бүртгэх, тоо бүртгэлийн үйл ажиллагаа төвлөрсөн, нууцлалыг хангасан байх, өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүр хийх, үнэн зөв, бүрэн мэдээлэлтэй байх зарчмыг хэрэгжүүлэх, төрийн албаны “Хүний нөөцийн мэдээллийн тогтолцоо” цахим систем дэх мэдээлэл, өгөгдлөөс Монгол Улсын хүний нөөцийн бодлогын хувилбар боловсруулах, төрийн байгууллага хооронд үнэн зөв мэдээллийг шуурхай солилцох үйл ажиллагааг дэмжих, тулгамдаж буй асуудлыг журмын хүрээнд шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

### **3.2.Засгийн газраас байгуулагдаж буй хороо, зөвлөл, комиссын Ажлын албанд ажиллаж буй албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох**

Засгийн газрын тогтоолоор шинээр байгуулагдаж буй хороо, зөвлөл, комиссын Ажлын алба, нэгжийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоож батлаагүйтэй холбоотой төрийн албаны “Хүний нөөцийн мэдээллийн тогтолцоо” цахим систем болон цалингийн системд тухайн албан хаагчийг бүртгэх боломжгүй нөхцөл байдал үүсч, ангилалгүй гэсэн бүртгэлээр бүртгэгдэж байна.

Иймд тухайн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэлд тусгаж, нэгдсэн зохицуулалтад оруулж, зөрчлийг арилгах шаардлагатай байна.

### **3.3.Төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн хүрээнд зохицуулах**

Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны зарим байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр жилд олон давтамжтай хийгдэж байгаа нь ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлөх, ажлын байрны чиг үүргийн давхардал бий болж, тогтвор суурьшилгүй байдал үүсэх зэрэг сөрөг үр дагаврууд гарч байна.

Тухайлбал, сүүлийн үед зарим яам, агентлагийн хувьд хууль тогтоомжоор чиг үүрэгт өөрчлөлт ороогүй байхад жил бүр бүтцийн өөрчлөлт хийж, төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг өөрчилж, давхардал үүсгэх, үндэслэлгүйгээр албан тушаалын ангилал, зэрэглэлийг өөрчилж, байгууллагын албан хаагч хооронд үл ойлголцол бий болгох, төрийн үйлчилгээний чанар хүртээмжид бус албан хаагчид чиглэсэн өөрчлөлт хөдөлгөөн хийж байна.

Иймд хууль тогтоомжоор тухайн байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон тохиолдолд төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоо, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж хэвших нь зүйтэй байна.

## **ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ХАМТАРСАН ТҮВШИНД**

### **4.1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах**

“Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулахад эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс, зэрэг дэвийг бууруулахгүй” гэж зааснаар төрийн байгууллагууд байгууллага дотор, нэгж хооронд шилжүүлэн ажиллуулах хүний нөөцийн шийдвэр гаргахдаа албан тушаалын зэрэглэл бууруулж томилох /жишээлбэл, ахлах мэргэжилтнээс мэргэжилтэн/, байгууллага хооронд сэлгэн ажиллуулахдаа хэдийгээр ангилал дотроо боловч тухайн салбараас хамаарч /АА, ТТ, ТЗ/ цалингийн зөрүү гарч байгаа ч өмнө эрхэлж байсан албан тушаалын цалин хөлсийг үргэлжлүүлэн олгож байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийг ижил ангилал, зэрэглэл, адил төрлийн албан тушаалд ажиллуулах, албан хаагч өөрөө хүлээн зөвшөөрч, албан тушаалын ангилал, эсхүл зэрэглэл буурч, төрөл өөрчлөгдөж шилжих болон сэлгэн ажиллаж байгаа тохиолдолд түүнд тухайн томилогдсон албан тушаалын цалин хөлсийг олгох тухай зохицуулалтыг журамд тусгаж, зөрчлийг арилгах;

Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн ажиллуулахдаа сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилогдсон тухайн албан тушаалд 1 жилээс доошгүй хугацаанд ажилласан байх, тодорхой ур чадвар, туршлага хуримтлуулсан байх шаардлагыг нэмэх;

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасан төрийн жинхэнэ албан хаагчийг тухайн байгууллагын нэгж хооронд шилжүүлэх зохицуулалтыг төрийн тусгай албан хаагчид “өөрт нь мэдэгдэн”, харин төрийн захиргааны албан хаагчийн хувьд “өөрийнх нь зөвшөөрлийг авч” шилжүүлэхээр өөрчлөх;

Төрийн үйлчилгээний болон төрийн улс төрийн албан тушаалаас төрийн жинхэнэ албанд шилжүүлэн, сэлгэн ажиллуулахыг хориглох;

Сэлгэн ажиллуулсан албан хаагчийн эзгүй байгаа ажлын байр хадгалагддаг тул албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх зохицуулалт нэмэх шаардлага гарч байна.

### **4.2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 36/32 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах**

Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт 48 дугаар зүйлийг бүхэлд нь нэрлэн заасан байхад тус журамд сахилгын шийтгэлийн төрлөөр нь буюу хугацаатай болон хугацаагүй халах шийтгэлийг Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийлгэж, Төрийн албаны зөвлөлөөр маргааныг шийдвэрлэхгүйгээр шууд шүүхэд хандуулж байгаа нь хуулийг зөрчсөн зохицуулалт болсон тул хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

## ТАВ. ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТҮВШИНД

### **5.1.Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Журам батлах тухай 71 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах журам”-ыг шинэчлэн батлах**

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн “Журам батлах тухай” 71 дүгээр тогтоолоор “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах журам, шагнуулах ажилтны тодорхойлолт, тэмдгийн үнэмлэхийн загварыг тус тус баталсан.

Тухайн үед мөрдөгдөж байсан төрийн албаны хууль тогтоомж хүчингүй болж, тогтоол хууль эрх зүйн үндэслэлгүй болсон, мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэрэгжиж эхэлснээр журамд төрийн албан хаагчийн ёс зүй, ур чадвар, сүүлийн 5 жилд үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээний шалгуурыг тусгах, шагналын нэр хүндийн нэмэгдүүлэх шаардлага бий болсон.

Иймд Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгийн журмын шинэчлэн баталж, хэрэгжүүлэх.

### **5.2.Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх**

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлд “20.2.Төрийн үйлчилгээний албан тушаалыг энэ хуулийн 18.1-д заасан төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын саналыг үндэслэн төрийн албаны төв байгууллага батална.” гэж 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар “удирдах” гэснийг хассан.

Иймд Төрийн албаны тухай хууль, Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэл баталсан Засгийн газрын тогтоолд нийцүүлэн төрийн үйлчилгээний албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах.

### **5.3.Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах**

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйл “4.1.11 дэх заалтад “хүний хувийн мэдээлэл” гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг ойлгоно.” гэж заасан.

Төрийн албан хаагчийн анкетыг зөвхөн төрийн байгууллага бус хувийн хэвшлийн хуулийн этгээд ашиглаж иргэний хувийн мэдээллийг цуглуулж байна. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу хүн өөрийн мэдээллээ өгөхийг зөвшөөрч баталгаажуулан гарын үсэг зурж байгаа боловч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн регистрийн дугаар анкетад ил бичигдэж байна.

Энэ нь хүн өөрийн мэдээллээ ашиглуулах зөвшөөрөл өгөх болон Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 5.12. -д заасан “...Иргэний бүртгэлийн дугаар нь төрсний, гэрлэсний, нас барсны улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, төрийн байгууллагаас олгох бусад баримт бичигт бичигдэнэ.” гэсэн заалтай зөрчилдөж байна.



Иймд Төрийн албан хаагчийн анкетад байгаа бөглөж буй өөрийн регистрийн дугаарыг улсын бүртгэлийн дугаараар, гэр бүлийн гишүүдийн регистрийн дугаарыг төрсөн огноогоор солих, хязгаарлалттай мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахгүй, задруулахгүй байх, хариуцлага хүлээх талаар анхааруулга оруулах, кирилл болон үндэсний хос бичгээр байхаар өөрчлөлт оруулах.

**5.4.Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 26 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах**

Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль хэрэгжсэнээр төрийн албан хаагчийн анкет, хувийн хэргийн бүрдэлд нэмэлт оруулах шаардлага үүсэж байна.

Төрийн тусгай чиг үүргийн байгууллагын зарим албан тушаал орхигдож, төрийн албан хаагчийн эрх ашиг хөндөгдөх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төвөгтэй нөхцөл үүссэн тул Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, зөрчлийг арилгах шаардлагатай байна.

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ